



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



Empowered lives.
Resilient nations.

“Монгол Улсын төлөөлийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл

2019 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2020 оны 4 сар

Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ТУХАЙ

Тайлан хамарч буй хугацаа	2019 оны 1 дүгээр сарын 1 - 12 дугаар сарын 31
Төслийн дугаар	МОН/17/101
Төслийн нэр	“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь”
Төсөл хэрэгжиж эхэлсэн огноо	2017 оны 1 дүгээр сарын 01
Төсөл хэрэгжиж дуусах огноо	2020 оны 12 дугаар сарын 31
Төслийг хамтран хэрэгжүүлэгч	Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБХХ
Төслийн төсөв /нийт/	3,800,000 ам.доллар
Санхүүжилт	ШХА 3,300,000 ам.доллар НҮБХХ 500,000 ам.доллар
НҮБХХ-ийн улс орны хөтөлбөрийн холбогдох үр дүн: 2021 гэхэд засаглалын байгууллагууд залуучуудын үр нөлөөтэй оролцоог хангаж, ядуу, эмзэг бүлгийн эрхийг хамгаалан, иргэдийн өмнө хүлээх хариуцлага дээшилнэ. Төслийн хүлээгдэж буй үр дүн: 1. Нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирсан байна. 2. ИТХ-ын зохион байгуулалтын чадавх сайжирсан байна. 3. Сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизм бий болсон байна. 4. УИХ-ын Тамгын газраас төлөөллийн байгууллагад дэмжлэг үзүүлэх чадавх дээшилсэн байна.	
2019 оны төсөв	1,212,944 ам.доллар
2019 оны төсвийн гүйцэтгэл (12 дугаар сарын 31-ний байдлаар)	898,193 ам.доллар

ТОВЧИЛСОН ҮГС

УИХ	Улсын Их Хурал
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗЗНДНТУТХ	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
НӨУБ	Нутгийн өөрөө удирдах байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ТББ	Төрийн бус байгууллага

АГУУЛГА

Төслийн 2019 онд хүрсэн үр дүн, үйл ажиллагаа	10
ХҮРЭХ ҮР ДҮН 1: Нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирсан байх	10
2019 онд хүрсэн үр дүн, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	10
Сорилт бэрхшээл, амжилтын хүчин зүйлс ба сургамж	15
Цаашид хийх ажил, тогтвортой байдал	16
ХҮРЭХ ҮР ДҮН 2: ИТХ-ын зохион байгуулалтын чадавх сайжирсан байх	17
2019 онд хүрсэн үр дүн, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	17
Сорилт бэрхшээл, амжилтын хүчин зүйлс ба сургамж	32
Цаашид хийх ажил, тогтвортой байдал	32
ХҮРЭХ ҮР ДҮН 3: Орон нутгийн сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизмтай болох	34
2019 онд хүрсэн үр дүн, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	34
Сорилт бэрхшээл, амжилтын хүчин зүйлс ба сургамж	41
Цаашид хийх ажил, тогтвортой байдал	42
ХҮРЭХ ҮР ДҮН 4: Сонгогдсон Төлөөлөгчдөд дэмжлэг үзүүлэх УИХ-ын Тамгын газрын чадавх сайжирсан байх	43
2019 онд хүрсэн үр дүн, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	43
Сорилт бэрхшээл, амжилтын хүчин зүйлс ба сургамж	55
Цаашид хийх ажил, тогтвортой байдал	55
Оролцогч талуудын хамтын ажиллагаа	56
Жендерийн асуудал	57
Төслийн удирдлага ба санхүүгийн удирдлага	57
Хавсралт	58

ОРШИЛ

“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн үндсэн зорилго бол бүх шатны ИТХ-ууд шийдвэр гаргах, төлөөлөх болон хяналтын чиг үүргээ илүү үр дүнтэй хэрэгжүүлэх замаар “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-ыг хангахад хувь нэмрээ оруулахад нь дэмжлэг үзүүлэх юм.

Нутгийн өөрөө удирдах байгууллагууд иргэдэд илүү нээлттэй, хариуцлагатай байж, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалахад Төсөл зохих хувь нэмрээ оруулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлэг буюу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагатай холбогдох асуудлаар өөрчлөлт орсон нь 2019 онд нутгийн өөрөө удирдах байгууллагын салбарт гарсан онцлог чухал үйл явдал байлаа.

Энэхүү тайлан нь төслийн гурав дахь жилийн хэрэгжилтийн тайлан бөгөөд 2019 онд хүрсэн гол үр дүн, хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тусгасан болно.

2019 ОНД ХҮРСЭН ГОЛ ҮР ДҮН

ҮР ДҮН 1	Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага”-ын үндсийг тодорхойлсон Дөрөвдүгээр бүлэгт 2019 оны 11 дүгээр сард нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд Төслийн хүрээнд хийгдсэн бодлогын судалгаа, зөвлөмж зохих хувь нэмрээ оруулав. Нутгийн удирдлагын чиглэлээрх мэргэшсэн экспертүүд ЗЗНДНТҮтХуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, зөвлөмжийг УИХ, Засгийн газар, орон нутгийн түвшний шийдвэр гаргагчдад хүргүүлсэн юм. Нутгийн удирдлагын эрх зүйн зохицуулалтын хүрээнд тулгамдсан асуудал, тэдгээрийн гарц шийдлийн талаар олон талуудыг оролцуулсан чуулган, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, санал солилцох, байр сууриа нэгтгэхэд дэмжлэг үзүүллээ. Мөн судалгаанд суурилсан, оролцогч талуудын саналыг тусгасан хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны дэргэдэх дэд ажлын хэсэгт хүлээлгэн өгөв. Эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын ур чадвар, урам зориг нэмэгдэж, ажил үүрэгт нь бодит тусгалаа олж байна. Бүх шатны 400 гаруй эмэгтэй төлөөлөгч, Монгол Улсын Их Хурал, Бутан, Швейцарын Холбооны Улсын парламентын эмэгтэй гишүүдийг оролцуулсан “Эмэгтэйчүүд манлайлал” чуулганыг зохион байгуулснаар ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид санаачлан хэрэгжүүлж буй сайн туршлагаа танилцуулах, харилцан суралцах боломжийг бий болгов. Чуулганаар орон нутгийн эмэгтэй улс төрчид сайн туршлагаа харилцан солилцож, төр, иргэний нийгэм, хувийн хэвшилтэй хэрхэн үр нөлөөтэй, шинэлэг байдлаар хамтран ажиллаж болох талаар хэлэлцэж, намын харьяалал, удирдлагын шатлалаас хамаарахгүйгээр хоорондоо хамтран ажиллахаа илэрхийлэв.
ҮР ДҮН 2	ИТХ-ын зохион байгуулалтын чадавхыг дээшлүүлэх зорилтын хүрээнд хурлын үйл ажиллагаанд баримтлах үлгэрчилсэн журмыг Төслийн хүрээнд боловсруулсан бөгөөд үүний дагуу 2019 онд 67 нийт ИТХ дэгээ шинэчлэн батлав. Энэ нь нийт аймгийн 23.8 хувь, сумдын 18.8 хувь болж байна. ИТХ-аас Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний акт боловсруулах, батлан гаргахад дэмжлэг үзүүлэх гарын авлага боловсруулав. Төслийн хүрээнд бий болсон эдгээр үр дүнг бэхжүүлэх, цаашид тогтвортой үргэлжлүүлэхэд аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын ажлын хэсэг идэвх санаачлагатай ажиллаж байна. ИТХ-аас хяналтын болон төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр гарч буй санал санаачлагыг дэмжих зорилготой тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд ИТХ-аас эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин, орон нутгийн төсөв зэрэг салбарт иргэдийн оролцоотой хяналт тавих, нутгийн удирдлагад залуучуудын оролцоог нэмэгдүүлэх

	санаачлагуудыг дэмжин хэрэгжүүлэв.
	Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, сайн туршлагын талаар телевизийн нэвтрүүлэг, богино хэмжээний сурталчилгааны бүтээгдэхүүн боловсруулж, олон нийтийн хүртээл болгосноор иргэдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, ИТХ-ын сайн туршлагыг нийтэд түгээв.
	Бүх шатны 360 гаруй ИТХ-уудыг нэгтгэсэн www.khural.mn цахим хуудсыг иргэд, ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны ажилтнууд ашиглахад илүү хялбар, хэрэгцээнд нийцсэн болгох зорилготой системийн болон техникийн шинэчлэлт хийж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэг орон даяар явагдсантай холбоотойгоор www.khural.mn цахим хуудаст шинэ цэс нээж, УИХ-ын цахим хуудастай шууд холбосноор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг ИТХ-ууд болон олон нийтэд танилцуулах сувгийг нэмсэн.
	Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хооронд харилцан туршлага солилцох, хамтын ажиллагаагаа бэхжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж 5 удаагийн бүсчилсэн хэлэлцүүлгийг ИТХ-уудтай хамтран зохион байгуулав. Үүний үр дүнд ИТХ-ууд үйл ажиллагаагаа илүү үр дүнтэй зохион байгуулах талаар сайн туршлагаасаа харилцан суралцав. Хэлэлцүүлэгт УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төлөөлөл оролцсон нь нутгийн удирдлагын эрх зүйн орчинд гарч буй сорилт бэрхшээл, шийдлийн талаарх орон нутгийн дуу хоолойг төрийн эрх барих дээд байгууллагын сонорт хүргэхэд чухал ач холбогдолтой байлаа.
	Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан орон нутгийн засаглал, нутгийн удирдлагын тогтолцоо хөгжсөн улс оронд ажиллаж, суралцсан туршлагад тулгуурлан тодорхой санал боловсруулж, ЗЗНДНТУХ-ийн шинэчилсэн найруулга, бусад хууль тогтоомжид тусгуулахаар хүргүүлсэн.
ҮР ДҮН 3	ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид манлайллын сургалтаар олж авсан мэдлэгтээ тулгуурлан санаачлан хэрэгжүүлсэн ажлуудыг сайн туршлагын эмхэтгэл болгон хэвлэж түгээсэн нь бусад эмэгтэй төлөөлөгчдөд шинэ сэдэл, урам зориг төрүүлж байна. Сонгогдсон төлөөлөгчдийн хэрэгцээний судалгаанд үндэслэн Удирдлагын академийн боловсруулж, зохион байгуулсан сэдэвчилсэн сургалтад 21 аймгийн ИТХ өөрийн ажлын албаны ажилтнууд, сумдын ИТХ-ын тэргүүлэгчдээ хамруулахаар саналаа ирүүлж, 51.4 сая төгрөгийг өөрсдийн төсвөөс санхүүжүүлсэн нь орон нутгийн төсвөөс сургалтын зардлыг санхүүжүүлэх замаар “...сургалтын хөтөлбөрүүдийг цаашид тогтвортой үргэлжлүүлэн хэрэгжүүлэх...” төслийн зорилтод хүрэх чухал алхам болов.

	Зүүн болон өмнөд Азийн 12 орныг нэгтгэсэн LOGIN нутгийн удирдлагын сүлжээ байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлж, гишүүн орнуудын сайн туршлага, эрдэмтэн судлаачдын мэдлэгийг өөрийн улсын нутгийн удирдлагын болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлж байна. Сургагч багш нарын дэмжлэгтэйгээр сумын ИТХ, багийн ИНХ-ыг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын үр дүнг бататгаж, практикт хэрэгжүүлэхэд нь зөвлөн туслав. Үүний үр дүнд сумын төдийгүй багийн ИНХ-ууд төслийн хүрээнд боловсруулсан хуралдааны үлгэрчилсэн дэгийн дагуу хурлын дэгээ шинэчлэн баталлаа. Төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтуудын үр дүнд орон нутгийн түвшинд гарч буй өөрчлөлт, сайн туршлагын талаар баримт мэдээлэл нэмэгдлээ. Нутгийн удирдлагын байгууллагууд харилцан туршлага солилцох лаборатори, орон нутгийн удирдлага, сайн туршлагын талаарх судалгаа, мэдээллийн бааз, төв орон нутгийг холбосон бодлогын хэлэлцүүлгийн талбар болж хөгжих Нутгийн удирдлагын сургалт судалгаа, мэдээллийн төвийг байгуулах эхний алхмыг хийлээ.
ҮР ДҮН 4	Улсын Их Хурлын хууль тогтоох болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чадавхыг дээшлүүлэхэд төслийн хүрээнд бий болсон мэдлэгийн бүтээгдэхүүнүүд тодорхой хувь нэмэр оруулж байна. Улсын Их Хурлын Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж холбогдох сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулж, “сургагч багш” нарыг бэлтгэв. Улсын Их Хурлын Тамгын газрын удирдах албан тушаалтнууд чадавхжуулах сургалтад хамрагдаж, манлайллын ур чадвараа дээшлүүлэв. Парламентын эрх зүйн тодорхой сэдэв, чиглэлээр хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, парламент дахь цөөнх, УИХ-ын хяналтын чиг үүргийн талаар судалгааны бүтээгдэхүүн гаргав. Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах явцад харьцуулсан мэдээллээр хангасны үр дүнд хууль тогтоох байгууллагын Стратеги төлөвлөгөөг орчин цагийн парламентын чиг хандлагад нийцүүлэх боломжийг бүрдүүллээ. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагаа тогтвортой үргэлжилж, хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх чадавх, туршлага нэмэгдэв. Хамтын ажиллагааны үр дүн, хуримтлуулсан туршлагад тулгуурлан УИХ-ын Тамгын газарт Хяналт шалгалт, үнэлгээний бие даасан нэгжийг шинэчлэн байгуулж, хүний нөөцийг нэмэгдүүлэв. Түүнчлэн хууль тогтоомжийн хэрэгжилт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, журмын төслийг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг харааны бэрхшээлтэй иргэд, үндэсний цөөнх буюу казах иргэдэд хүртээмжтэй байдлаар хүргэх нөхцөл бүрдсэн нь шинэ практик болж байна.
--

ТӨСЛИЙН 2019 ОНД ХҮРСЭН ҮР ДҮН, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХҮРЭХ ҮР ДҮН 1: НУТГИЙН УДИРДЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН САЙЖИРСАН БАЙХ

2019 онд хүрсэн үр дүн, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага”-ын үндсийг тодорхойлсон Дөрөвдүгээр бүлэгт 2019 оны 11 дүгээр сард нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд Төслийн хүрээнд хийгдсэн бодлогын судалгаа, зөвлөмж зохих хувь нэмрээ оруулав. Нутгийн удирдлагын чиглэлээрх мэргэшсэн экспертүүд ЗЗНДНТУТХуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, зөвлөмжийг УИХ, Засгийн газар, орон нутгийн түвшний шийдвэр гаргагчдад хүргүүлсэн юм.

Нутгийн удирдлагын эрх зүйн зохицуулалтын хүрээнд тулгамдсан асуудал, тэдгээрийн гарц шийдлийн талаар олон талуудыг оролцуулсан чуулган, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, санал солилцох, байр сууриа нэгтгэхэд дэмжлэг үзүүлээ. Мөн судалгаанд суурилсан, оролцогч талуудын саналыг тусгасан хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулаж УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны дэргэдэх дэд ажлын хэсэгт хүлээлгэн өгөв.


“Нутгийн удирдлагатай холбоотой хууль тогтоомж болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх” зөвлөх үйлчилгээг “MDS KhanLex” хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл гүйцэтгэж, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгын саналыг боловсруулсан. Тайлант хугацаанд зохион байгуулагдсан чуулган, хэлэлцүүлэг, бүсийн уулзалтууд зэрэг арга хэмжээний үеэр хуулийн төслийг танилцуулж, оролцогч талуудаар хэлэлцүүлэн саналыг нь тусгав. Одоо хэрэгжиж буй Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, тулгамдаж буй асуудал, ирээдүйд учирч болох үр дагаврыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалсан дүгнэлтэд үндэслэсэн, өргөн хүрээг хамарсан хэлэлцүүлгээс гарсан саналыг тусган боловсруулсанаараа энэхүү хуулийн төсөл нь онцлог болж байна.

Нутгийн удирдлагын тогтолцоо, эрх зүйн орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломж, арга, шийдлийн талаар хэлэлцэн, эрх зүйн орчныг сайжруулах санал зөвлөмж гаргах зорилгоор УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хороо, Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран “Нутгийн удирдлагын тогтолцоо, эрх зүйн шинэчлэл” чуулганыг 1 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулав. Чуулганд бүх шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын төлөөлөл буюу нийслэл хот, 21 аймгийн ИТХ-ын дарга, төлөөлөгчид, Засаг дарга, сум, дүүрэг, багийн ИТХ, ИНХ, Засаг дарга нар болон УИХ, Засгийн газар, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагаас 300 орчим төлөөлөгч оролцож, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээтэй танилцаж, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах үндсэн асуудлуудыг хэлэлцэв.



“Нутгийн удирдлагын тогтолцоо, эрх зүйн шинэчлэл” чуулга, 2019.01.15-16

- Чуулганд нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага, төрийн албаны шинэчлэл ба төвлөрлийг сааруулах бодлого, орон нутгийн төсвийн эрх мэдэл, орон нутгийн төлөөллийн болон гүйцэтгэх байгууллага хоорондын харилцаа, Азийн улс орнуудын нутгийн удирдлагын тогтолцоо, бие даасан байдлыг хангаж буй туршлага зэрэг сэдвээр УИХ, Засгийн газар, орон нутгийн удирдлага, судлаачдын төлөөлөл илтгэл тавив.
- Чуулганы оролцогчид *аймаг; сум, баг; нийслэл, дүүрэг хороо; төрийн байгууллага* гэсэн дөрвөн салбар хуралдаанаар хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэв. Засаг захиргааны шат шатны нэгжийн бие даасан байдал, чиг үүрэг, эдийн засгийн үндэс, төв орон нутаг болон салбар дундын харилцан уялдааг зохистой хангах талаар амьдралд туршигдсан олон санал гаргасан нь хуулийн төсөлд тусгагдсан.
- Чуулганд тавигдсан илтгэл мэдээлэл, хэлэлцүүлгийн явцад гарсан асуулт хариулт, санал шүүмжлэлд үндэслэн Зөвлөмж гаргасныг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов.



“Нутгийн удирдлагын тогтолцоо, эрх зүйн шинэчлэл” чуулганы илтгэлүүд

Нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэд хэдэн удаа хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа.

- “Нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлэг 3 дугаар сарын 15-ны өдөр Төрийн ордонд болов. Монгол Улсын Их Хурлын даргын улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд онцгой нөлөөтэй зарим салбарын эрх зүйн шинэчлэлийн асуудлаар цуврал хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах тухай санаачлагын хүрээнд тус хэлэлцүүлэг хийгдсэн бөгөөд судлаач Д.Ганзориг “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн

шинжилгээ”, “ЭмДиЭс ХаанЛекс” ХХН-ийн гишүүн Ж.Майзориг “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөлд оруулах үндсэн асуудлууд” Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга С.Сүхбаатар “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөлд орон нутгийн төлөөллийн байгууллагаас өгөх санал”, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал “Төв, орон нутаг болон салбар хоорондын уялдаа холбоог хангахад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” зэрэг сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв. Хэлэлцүүлэгт УИХ, Засгийн газар, зарим аймаг, нийслэл, дүүргийн нутгийн өөрийн удирдлагын болон төрийн захиргааны байгууллагын удирдлагын төлөөлөл оролцов.



*“Нутгийн удирдлагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” хэлэлцүүлэг
Төрийн ордон, 2019.03.15*

- Хэнтий аймгийн Чингис хотод 5 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан зүүн бүсийн буюу Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн ИТХ-ын Ажлын албаны “Зүүн бүс-3” зөвлөлдөх уулзалтын үеэр “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн тулгамдсан асуудал” сэдвээр хэлэлцүүлэг хийж, саналаа нэгтгэн ЗЗНДНТУХ-ийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, ЗГХЭГ-ын төлөөлөлд танилцуулав.
- Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод 6 дугаар сарын 02-ны өдөр “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг боловсронгуй болгох нь” сэдэвт бүсчилсэн хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн нутгийн өөрийн удирдлага, нутгийн захиргааны бүх шатны байгууллагын төлөөлөл болон дэд ажлын хэсгийн ахлагч, гишүүд, ЗГХЭГ, Төслийн нэгж, “Эм Ди Эс Хаанлекс” нөхөрлөлийн хуулийн төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл оролцов. УИХ-ын гишүүн, Төвлөрлийг сааруулах эрх зүйн орчныг судалж, санал дүгнэлт гаргах УИХ-ын дэд ажлын хэсгийн ахлагч Д.Тогтохсүрэн Монгол Улсын Үндсэн хуульд нутгийн удирдлагын чиглэлээр оруулахаар боловсруулсан нэмэлт, өөрчлөлтийн санал, ЗЗНДНТУХ-ийг шинэчлэх хэрэгцээ шаардлагын талаар танилцуулж, оролцогчидтой санал солилцлоо.
- Улаанбаатар хот, “Хангарьд” ордонд 11 дүгээр сарын 20-ны өдөр “Нутгийн удирдлагын эрх зүйн орчин, ИТХ-уудын сайн туршлага” хэлэлцүүлэг болов. Хэлэлцүүлгийг Монголын нутгийн удирдлагын холбоотой хамтран зохион байгуулсан бөгөөд аймаг, дүүргийн ИТХ-ын дарга нар оролцож, Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлэг буюу нутгийн удирдлагын талаарх нэмэлт, өөрчлөлтийн дагуу ЗЗНДНТУХ, бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар хэлэлцэв. Аймгийн ИТХ-ын дарга нар тодорхой өөрсдийн саналыг

нэгтгэн ирүүлэх, дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах боломжтой талаараа УИХ, Засгийн газарт уламжлахаар тогтов.



Эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын үр чадвар, урам зориг нэмэгдэж, ажил үүрэгт нь бодит тусгалаа олж байна. Бүх шатны 400 гаруй эмэгтэй төлөөлөгч, Монгол Улсын Их Хурал, Бутан, Швейцарын Холбооны Улсын парламентын эмэгтэй гишүүдийг оролцуулсан “Эмэгтэйчүүд манлайлал” чуулганыг зохион байгуулснаар ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид санаачлан хэрэгжүүлж буй сайн туршлагаа танилцуулах, харилцан суралцах боломжийг бий болгов. Чуулганаар орон нутгийн эмэгтэй улс төрчид сайн туршлагаа харилцан солилцож, төр, иргэний нийгэм, хувийн хэвшилтэй хэрхэн үр нөлөөтэй, шинэлэг байдлаар хамтран ажиллаж болох талаар хэлэлцэж, намын харьяалал, удирдлагын шатлалаас хамаарахгүйгээр хоорондоо хамтран ажиллахаа илэрхийлэв.

Төслийн хүрээнд 2018 онд зохион байгуулагдсан төлөөлөгч эмэгтэйчүүдийн манлайллын сургалтын үр дүнд орон нутгийн тулгамдсан асуудлыг хүчин чармайлт, санаачлага гарган шийдвэрлэсэн олон бодит жишээ гарсан. Эдгээр сайн туршлагуудыг олон нийтэд танилцуулах, туршлага хуваалцах зорилгоор “Эмэгтэйчүүд-Манлайлал” чуулганыг 6 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулав. Орон нутгийн эмэгтэй улс төрчдийн ололт амжилтыг танилцуулж, харилцан туршлага солилцох, дуу хоолойгоо нэгтгэх, сайн туршлагуудаас санаа авч ажиллах бүтээлч хэв маягийг орон даяар түгээн дэлгэрүүлэхэд чуулганы зорилго оршиж байв. Чуулганд аймаг, нийслэл, сум, дүүргийн Төлөөлөгч эмэгтэйчүүд, УИХ, Засгийн газар, төрийн байгууллага, олон улсын байгууллагын 400 гаруй эмэгтэй төлөөлөл оролцов.

- Швейцарын Холбооны Улсын Үндэсний зөвлөлийн дарга Марина Кароббио Гүшэтти “Улс төр дэх эмэгтэйчүүд-миний улс төрийн замнал”, УИХ-ын гишүүн Н.Амарзаяа “Бүх шатны засаглалын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн үүргийг нэмэгдүүлэх нь”, “МонФемНет” үндэсний сүлжээний ерөнхий зохицуулагч Д.Энхжаргал “Улс төр дэх эмэгтэйчүүд-сорилт, боломж” сэдвээр илтгэл тавьж, аймаг, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч эмэгтэйчүүд өөрийн санаачлан хэрэгжүүлсэн сайн туршлагуудаас танилцуулав.
- Чуулганд оролцогчид “Иргэдтэй ажиллах үр дүнтэй арга замууд”, “Төрийн болон улс төрийн намын тогтолцоонд амжилт гаргах арга замууд”, “Эмэгтэйчүүдийн дуу хоолой болж ажиллах нь”, “Иргэний нийгэм, хувийн

хэвшилтэй хамтран ажиллах арга барил” сэдвүүдээр салбар хуралдаанд оролцож санал солилцов.

- Чуулганд Швейцар, Бутан улсын парламент, Зүүн болон өмнөд Азийн 12 орныг нэгтгэсэн LOGIN нутгийн удирдлагын сүлжээ байгууллагын төлөөлөл оролцсон нь олон улсын сайн туршлагаас суралцах боломжийг мөн олгосон.
- ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн санаачлан хэрэгжүүлсэн ажлын эмхэтгэл хэвлэгдсэн нь чуулганы үеэр оролцогчдод хүргэгдсэний зэрэгцээ сайн туршлагын үзэсгэлэн танилцуулагдсан.
- Чуулганд оролцсон эмэгтэйчүүд хамтын мэдлэг, туршлагадаа тулгуурлан, хүчин санаачлага, чармайлт гарган, нийгмийн бүлгүүдийн эрх ашиг сонирхлыг орон нутгийн хөгжлийн бодлогод тусгуулан хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллаж, харилцан суралцахаа илэрхийлж Уриалга гаргав.



“Эмэгтэйчүүд манлайлал” чуулган, Улаанбаатар хот, 2019.06.25

Чуулганд оролцсон төлөөлөгч эмэгтэйчүүдээс хийж хэрэгжүүлсэн ажлынх нь талаар болон чуулганд оролцсоноор олж авсан шинэ санаа, цаашид тодорхой ажлыг шийдвэрлэхэд манлайлан ажиллах төлөвлөгөө зэргийн талаар санал асуулга авав. Санал асуулгад 200 гаруй төлөөлөгч хамрагдсан.

Дотуур байрны сурагчдын сурах, амьдрах орчинг сайжруулах хүрээнд “Дотуур байр-хөгжих орчин” төсөл боловсруулж, Боловсролын яаманд хүргүүлснээр төсөл маань хэрэгжих боломжтой болоод байна.

(Хэнтий аймгийн Мөрөн сумын төлөөлөгч Н.Даваажав)

Өрхийн эрүүл мэндийн төв байсан, 2 жил ашиглагдаагүй байрыг улсын цэцэрлэгийнхээ салбар бүлэг болгох ажлыг санаачилж, 2 бүлэгт 50 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаар 2018 онд ашиглалтад оруулсан.


(Нийслэлийн Чингэлтэй дүүргийн төлөөлөгч Б.Соёл-Эрдэнэ)

Энэ чуулганд оролцсоноор ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаандаа тусгаж авах шинэ санаа, сайн туршлага олж авч чадсан эсэхийг тодруулахад:

- Эхэлсэн ажлаа шантралгүй дуусгаж, үр дүнг нь үзэх хэрэгтэй юм байна.
- Олон сайхан санаа олж харлаа. Сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт хамруулах ажлыг олон хувилбараар шийдэж болох тухай санаа төрсөн.
- Ард түмнийхээ амьдралтай илүү ойр байж, тулгамдаж буй асуудлыг хамтын хүчээр шийдвэрлэж байгаа олон сайн туршлагатай танилцлаа.
- Сумандаа очоод нийгэм рүү хандсан ажил хийхээр олон туршлага сонслоо. Би малын эмч мэргэжилтэй. Манай сум эрүүл мах бэлтгэдэг сум болгохын төлөө малчидтай хамтарч ажиллана.
- Эмэгтэйчүүд өөрсдийн хийсэн ажлаа нийгэмд сурталчилж байх хэрэгтэй юм байна.

- Энэ чуулганд оролцсоноор багаар ажиллах, сэдэлжүүлэх, хамтран ажиллах олон арга туршлага олж авлаа.
- Дахин нэр дэвшихгүй гэж бодож байсандаа дүгнэлт хийлээ. Бидний дуу хоолой байх нь хэрэгтэй.
- Энэ чуулган өвөрмөц болж байна. Сайн туршлага сонсоод санаа авах зүйл их байна.
- Эмэгтэй төлөөлөгчид бол бусдаас ялгарч, сонгогдож гарсан, иргэдийнхээ төлөө сэтгэл зүрхээ зориулсан, хийх гэсэн, санаачилсан зүйлийнхээ үр дүнг үзэхийн төлөө ажилладаг, уйгагүй хүмүүс байдаг юм байна гэжээ.

Түүнчлэн санал асуулгын хуудсаар Төлөөлөгчдөөс цаашид ямар чиглэлээр ур чадвараа сайжруулах хэрэгтэй, чадавхжуулах үйл ажиллагааг ямар байдлаар зохион байгуулах нь үр дүнтэй талаар тодруулахад санал асуулгад оролцогчдын дийлэнх хувь нь мэдээлэл цуглуулах, судалгаа дүн шинжилгээ хийх; нөлөөллийн ур чадвараа дээшлүүлэх хэрэгтэй бөгөөд бусад ИТХ-ын туршлагаас суралцах нь үр дүнтэй гэж хариулсан байна.



Сорилт бэрхшээл, амжилтын хүчин зүйлс ба сургамж

- Нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төслийг өргөн хүрээнд хэлэлцүүлж, оролцогч талуудын саналыг авч тусгахад Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Төвлөрлийг сааруулах эрх зүйн орчныг судалж, санал дүгнэлт гаргах Ажлын хэсгийн оролцоо, дэмжлэг чухал нөлөө үзүүлэв.
- 2019 оны эхний хагас жилд үндэсний хэмжээний томоохон хоёр чуулган (“Нутгийн удирдлагын тогтолцоо, эрх зүйн шинэтгэл”, “Эмэгтэйчүүд манлайлал”) зохион байгуулсан бөгөөд төслийг хамтран хэрэгжүүлэгч талуудын идэвхтэй оролцоо нь эдгээр чуулганы нэр хүндийг өсгөсний зэрэгцээ төслийг голлон хэрэгжүүлэгч УИХ-ын Тамгын газрын холбогдох хэлтэс, нэгжүүд зохион байгуулалт, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилласан нь амжилтад нөлөөлсөн нэг хүчин зүйл болов.
- Төслийн хүрээнд ЗЗНДНТУХ-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулагдсан байсан нь Монгол Улсын Үндсэн хуульд нутгийн удирдлагын чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой хэлэлцүүлгүүдэд концепцийн чухал хувь нэмэр үзүүлэв.

Цаашид хийх ажил, тогтвортой байдал

- Монгол Улсын Их Хурлын хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд ЗЗНДНТУХ-ийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу боловсруулан, өргөн мэдүүлж, хэлэлцэхээр тусгагдсан. Төслийн хүрээнд хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байна.
- Хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг судалгаа, нотлох баримтад тулгуурласан байдлаар боловсруулахын тулд орон нутгийн эдийн засгийн үндэс, хотын эрх зүйн зохицуулалт зэрэг шаардлагатай асуудлаар нэмэлт судалгаа, дүн шинжилгээ хийлгэж, хуулийн төсөл боловсруулагчдыг мэдээллээр хангана.
- Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг иргэдэд энгийн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хэвлэж хүргэхээр ажиллаж байна. /Үр дүн 4 хэсгээс дэлгэрэнгүйг үзнэ үү./

Төслийн үр дүнгийн хүснэгт /Хүрэх Үр дүн 1-ийн хүрээнд/

Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт/он		Зорилт	2019 онд хүрсэн түвшин	2017-2019	Мэдээлэл, нотолгооны эх сурвалж
1.1. нутгийн удирдлагын чиглэлээрх хуулийн нэмэлт өөрчлөлт хүлээн зөвшөөрөгдсөн байх.	-	2016	2018	Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө буюу 2019 оны 4 сард ЗЗНДНТУХ-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл танилцуулагдсан.	Биелэгдсэн. ЗЗНДНТУХуульд хийсэн харьцуулсан судалгаа болон нэмэлт өөрчлөлтийн төслийн санал бэлэн болж, ТББХ-нд танилцуулагдсан.	www.legalinfo.mn http://forum.parliament.mn/projects/10803
1.2.төслийн дэмжлэгтэй-гээр боловсруулсан бодлогын судалгааны зөвлөмжийг хүлээн авсан хувь хэмжээ	-	2016	70%	Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь ЗЗНДНТУХуульд хийсэн судалгааны дүн шинжилгээ, зөвлөмжид үндэслэсэн.	Биелэгдсэн. Үндсэн хуулийн нутгийн удирдлагатай холбоотой бүлэгт оруулсан нэмэлт өөрчлөлт нь ЗЗНДНТУХуульд хийсэн судалгааны дүн шинжилгээ, зөвлөмжид үндэслэсэн; 2019 оны 1 сард болсон Нутгийн удирдлагын тогтолцоо, эрх зүйн шинэтгэл чуулганаас гарсан сумын төсвийн татварын орлогыг бүрдүүлэх газрын төлбөрийн хувь хэмжээг өөрчлөх асуудал Төсвийн хуульд тусгагдсан. /23.8.4/	www.legalinfo.mn

ХҮРЭХ ҮР ДҮН 2: ИТХ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧАДАВХ САЙЖИРСАН БАЙХ

2019 онд хүрсэн үр дүн, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

ИТХ-ын зохион байгуулалтын чадавхыг дээшлүүлэх зорилтын хүрээнд хурлын үйл ажиллагаанд баримтлах үлгэрчилсэн журмыг Төслийн хүрээнд боловсруулсан бөгөөд үүний дагуу 2019 онд нийт 67 ИТХ дэгээ шинэчлэн батлав. Энэ нь нийт аймгийн 23.8 хувь, сумдын 18.8 хувь болж байна.

ИТХ-аас Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний акт боловсруулах, батлан гаргахад дэмжлэг үзүүлэх гарын авлага боловсруулав. Төслийн хүрээнд бий болсон эдгээр үр дүнг бэхжүүлэх, цаашид тогтвортой үргэлжлүүлэхэд аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын ажлын хэсэг идэвх санаачлагатай ажиллаж байна.

ИТХ-ыг чадавхжуулах чиглэлээр төслийн хүрээнд бий болсон мэдлэг, мэдээлэл, хөтөлбөр, үйл ажиллагаа, түүний үр дүнг бэхжүүлэх, цаашид тогтвортой үргэлжлүүлэхэд аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нар анхаарал хандуулж, үлгэрчилсэн дэгийг нэвтрүүлэх, ажлын гүйцэтгэлийн багц үзүүлэлтийг боловсруулах, ажлын албыг чадавхжуулах сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөө гаргах зэрэг төслийн гол хүрэх үр дүнгийн чиглэлээр зургаан ажлын хэсэг болж, төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллав.

Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын уулзалт семинарыг хоёр удаа зохион байгуулав.

- Нарийн бичгийн дарга нарын ажлын хэсгүүдийн 2019 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, төслийн хүрээнд төлөвлөсөн бусад үйл ажиллагаанд нарийн бичгийн дарга нарын саналыг авах зорилгоор 3 дугаар сарын 1-ний өдөр НҮБ-ын Төв байранд эхний уулзалт семинарыг зохион байгуулав:
 - Нарийн бичгийн дарга нарын Ажлын хэсгүүдийн 2019 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, төслийн хүрээнд зохион байгуулагдах бүсчилсэн уулзалт, тэтгэлэгт хөтөлбөр, харилцан суралцах хөтөлбөр зэргийн талаар санал солилцов.
 - Удирдлагын академийн сэдэвчилсэн, бататгах сургалтад төлөөлөгч, ажлын албаны ажилтнуудаа хамруулах, ингэхдээ зардлын тодорхой хэсгийг аймгийн ИТХ-аас санхүүжүүлэх боломжтойгоо илэрхийлэв.
 - Харилцан суралцах арга зүйгээс суралцаж, өөрийн ИТХ-ын сайн туршлагаас танилцуулав.






- “Орон нутгийн түвшинд засаглалыг сайжруулж, хөгжлийг хангах нь” сэдэвт уулзалт семинар 9 дүгээр сарын 25-нд Удирдлагын академийн төв байранд болов. Уулзалт семинарт 21 аймаг, 9 дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар болон ажлын албаны төлөөлөл, УИХ-ын Тамгын газар, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төлөөлөл, нутгийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн судлаачид зэрэг 90 орчим хүн оролцож, орон нутгийг хөгжүүлж, иргэдийн аж амьдралыг сайжруулахын тулд нутгийн өөрөө удирдах ёсыг зүй зохистой хэрэгжүүлэх, орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг дээшлүүлэх арга замын талаар хэлэлцэв. Түүнчлэн орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, иргэдийн эрх зүйн ухамсар, улс төрийн соёл, мэдлэгийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний үр нөлөөг дээшлүүлэх зэрэг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2020-2045 баримт бичигт тусгагдсан зарим асуудлаар мэдээлэл өгч, санал солилцов.



ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын ажлын хэсгийн үйл ажиллагаа:

- ИТХ-аас захиргааны хэм хэмжээний акт гаргах ажиллагааны талаар зөвлөмж боловсруулах чиглэлээр:
 - Төслийн хүрээнд ИТХ-аас захиргааны хэм хэмжээний акт гаргах ажиллагааны талаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор гарын авлага боловсруулж, www.khural.mn цахим хуудаст нийтэлсэн. Төслийн нэгжээс тус гарын авлагын хэрэглээ болон, энэ чиглэлээр цаашид хэрэгжүүлэх шаардлагатай ажлыг тодорхойлох судалгааг нарийн бичгийн дарга нараас авав:





- Нарийн бичгийн дарга нарын ажлын хэсэг 4 болон 11 дүгээр сард 2 удаа уулзаж, санал солилцон шалгах хуудас (check list) бүхий хялбаршуулсан гарын авлага боловсруулав. Гарын авлагыг 2020 оны эхний улиралд багтаан хэвлүүлж, аймаг, сум, дүүргийн ИТХ-уудад хүргэнэ.
- Үлгэрчилсэн дэгийн төсөл боловсруулж, нэвтрүүлэх чиглэлээр:
 - Төслийн нэгжээс үлгэрчилсэн дэгийн төслийг боловсруулж нэвтрүүлэх талаар судлан үзэхийг хүссэн албан бичгийг 2018.11.15-нд ИТХ-уудад хүргүүлсэн. Үүний дагуу 5 аймгийн ИТХ дэгээ шинэчлэн баталсан бол 6 аймаг нэвтрүүлэх боломжгүй гэсэн байна. Шалтгаан нь:
 - “өөрийн батлагдсан дэгтэй харьцуулан судлаж байгаа, ихэнх зүйл давхцаж байгаа тул яаран өөрчлөөгүй” /Хөвсгөл аймгийн ИТХ/
 - “ИТХ-ын Тэргүүлэгчид өмнөх дэгээ өөрчлөх шаардлагагүй гэж үзэж байгаа” /Завхан аймгийн ИТХ/
 - “манай дэгтэй төстэй байсан. Бүрэн эрх дунд бараг дуусч байхад хурлын дэг ярихаар эмх замбараагүй зүйл нэмж оруулах эрсдэлтэй байна.Тиймээс бүрэн эрх эхлэх үед барих боломж байна.” /Увс аймаг/ гэжээ.
 - ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын ажлын хэсгийн санаачилгаар 10 дугаар 17-ны өдөр Архангай аймгийн Ихтамир сумын ИТХ-ын төлөөлөгчид үлгэрчилсэн дэгийг өөрийн хурлын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дэгтэй харьцуулан судалж хэлэлцэв. Хэлэлцүүлгийн явцад ИТХ-ын төлөөлөгчид дэгийн олон асуудлыг нарийвчлан авч үзэж, ойлголт байр сууриа нэгтгэсэн юм. Үүний үр дүнд Ихтамир сумын ИТХ 12 дугаар сарын 13-ны өдөр хуралдааны дэгээ шинэчлэн баталлаа.
 - 2019 оны байдлаар нийт 5 аймаг, 62 сумын ИТХ үлгэрчилсэн дэгийн дагуу өөрийн хуралдааны дэгээ шинэчлэн батлаад байна. Энэ нь нийт аймгийн 23.8 хувь, сумдын 18.8 хувь болж байна.



- www.khural.mn цахим хуудасны хөтлөлт, хөгжүүлэлт, админы сургалтын агуулгын талаар санал боловсруулах чиглэлээр:

Цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт санал өгсөн бөгөөд цаашид гүйцэтгэлийн явцад нь хяналт тавих, тайланд санал зөвлөмж өгөх ажлыг гүйцэтгэнэ.


- ИТХ-ын үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны чиглэлээр:

Ажлын хэсэг 4 дүгээр сарын 12-ны өдөр Улаанбаатар хотод уулзаж, иргэдтэй харилцах, иргэдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр ИТХ-аас батлан хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төлөвлөгөөний нийтлэг асуудлын талаар санал солилцов. Төслийн хүрээнд мэдээлэл сурталчилгааны зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгчийн ажлын явцад санал өгч ажиллав.

ИТХ-аас хяналтын болон төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр гарч буй санал санаачлагыг дэмжих зорилготой тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд ИТХ-аас эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин, орон нутгийн төсөв зэрэг салбарт иргэдийн оролцоотой хяналт тавих, нутгийн удирдлагад залуучуудын оролцоог нэмэгдүүлэх санаачлагуудыг дэмжин хэрэгжүүлэв.

ИТХ-ын хяналтын болон төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх санал, санаачилгыг дэмжиж, сайн туршлага бий болгох, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, ИТХ-ыг чадавхжуулах зорилгоор жил бүр тэтгэлэгт хөтөлбөр зарладаг.

- 2019 оны ИТХ-ыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрийг 3 дугаар сард зарлаж, ирүүлсэн саналуудыг УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар байгуулагдсан Санал шалгаруулах хороо үнэлэв. Сонгон шалгаруулалтын дүнд 2 аймаг, 2 дүүрэг, 16 сумын ИТХ-ын санал шалгарч, төсөл хэрэгжүүллээ.
- Энэ удаагийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх төсөл санаачилгууд илүү олон байсан нь өмнөх онуудтай харьцуулахад онцлог байлаа.



2019 оны тэтгэлэгт хөтөлбөр			
	ИТХ	Чиглэл	Хүрсэн үр дүн
1.	Баянхонгор аймаг	ИТХ-ын шийдвэр-хяналт оролцоо	“Мини парламент” арга хэмжээ зохион байгуулснаар НӨУБ-ын талаар сурагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлэв. Аймгийн ИТХ-аас 1992-2019 оны хооронд батлагдсан 3691 тогтоолоос бодлогын шинжтэй тогтоолыг түүвэрлэн дүн шинжилгээ хийв.
2.	Сүхбаатар аймаг	Хяналт: ОНХС	3 сумын ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийв. Хяналтын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулав.
3.	Багануур дүүрэг	Хяналт: Эрүүл мэндийн салбарын чанар хүртээмж	Дүүргийн эрүүл мэндийн үйлчлэгээний чанар, хүртээмжид иргэдийн оролцоотой хяналт үнэлгээ хийв.
4.	Налайх дүүрэг	Хяналт: Олон нийтийн хяналтын зөвлөл	Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүд хяналт үнэлгээ хийх чиглэлээр чадавхиж, ажилах журам, маягт бүхий гарын авлагаар хангагдав. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй 60 гаруй төсөл, арга хэмжээнд 300 гаруй иргэн үнэлгээ өгөв.
5.	Баянхонгор, Жаргалант	Хяналт: Ерөнхий боловсролын чанар, хүртээмж	Сумын ЕБС-ийн Цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийв.
6.	Булган, Могод	Иргэдийн оролцоотой хяналт	Баг бүрт иргэдийн хяналтын баг байгуулагдав.
7.	Говь-Алтай, Бугат	Залуучуудын оролцоо	Залуучуудын чуулга уулзалт, сургалт зохион байгуулж, нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх залуучуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэв.
8.	Дорноговь, Даланжаргалан	Хяналт: Байгаль орчин	Уул уурхай, байгаль орчны асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдийн оролцоог хангав. Байгаль орчны чиглэлээр 3 удаа хяналт шалгалт хийв.
9.	Дорнод, Булган	Иргэдийн оролцоотой хяналт: Сум хөгжүүлэх сан	ИТХ-аар шинэчлэгдэн байгуулагдсан СХС-ийн зээл олгох зөвлөлийн гишүүд, 5 багийн “Иргэдийн хяналтын зөвлөл”-ийн гишүүдийг чадавхжуулав.
10.	Дундговь, Луус	Иргэдийн оролцоотой хяналт: Байгаль орчин	Олборлох салбарын үйл ажиллагаанд орон нутгийн иргэд оролцох, хяналт тавих талаар чадавхжсан. Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах журмын төсөл боловсруулсан.
11.	Дундговь, Өлзийт	Хяналт: ИТХ-ын хороог чадавхжуулах	Төлөөлөгчид дадлага ажил хийх замаар бодлогын баримт бичигт хяналт үнэлгээ хийх арга зүйд суралцав. Ажлын хороодоос хяналт үнэлгээ хийх журам боловсруулав.

12.	Дундговь, Хулд	Иргэдийн оролцоотой хяналт: ОНХС	Сумын 60 гаруй иргэн сургалтад хамрагдаж, ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр чадавхжив. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг ИТХ-аар батлах арга зүйн зөвлөмж боловсруулав.
13.	Завхан, Их-Уул	Иргэдийн оролцоотой хяналт: ОНХС	ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хяналт тавих тухай” журмын төслийг иргэдийн оролцоотой боловсруулж баталсан. Хяналтын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулж, ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хийгдсэн ажилд хяналт үнэлгээ хийсэн.
14.	Сэлэнгэ, Сүхбаатар	Иргэдийн оролцоотой хяналт: Орон нутгийн төсөв	Сумын ИТХ-ын Хяналтын хорооны дэргэдэх салбар хороо байгуулж, ажиллах журмыг баталсан. Удирдамжийн дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын гүйцэтгэл, явцад хяналт үнэлгээ хийсэн.
15.	Сэлэнгэ, Хүдэр	Хяналт: Байгаль орчныг хамгаалах дэд хөтөлбөр боловсруулах нь	Сумын байгаль орчны талаар баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийсэн. Байгаль орчныг хамгаалах дэд хөтөлбөр боловсруулж баталсан.
16.	Увс, Өндөрхангай	Залуучуудын оролцоо	Тус сумын 18-35 насны 300 гаруй залуучуудын санал тусгагдсан “Сумын залуучуудын хөгжлийн дэд хөтөлбөр”-ийг ИТХ-аар батлав.
17.	Увс, Хяргас	Хяналт: Төлөөлөгчдийг чадавхжуулах	Сумын ИТХ-ын төлөөлөгчдөд НӨУБ-ын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, иргэдийг оролцуулах агуулгаар сургалт зохион байгуулав.
18.	Хөвсгөл, Галт	Залуучуудын оролцоо	Сумын нийт залуучуудын 20 хувь буюу 300 гаруй залуучуудын санал тусгагдсан “Залуучуудын хөгжлийн хөтөлбөр” батлагдав. Залуучуудын төлөөлөл ИТХ-ын хуралдаанд оролцож саналаа хэлэв.
19.	Хөвсгөл, Төмөрбулаг	Хяналт: ОНХС	Тус сумын 5 багийн ИНХ-аар баг тус бүрт “Иргэний хяналтын зөвлөл”, “Мэдээллийн хөтөч баг” байгуулагдаж, ажиллах журам батлагдав. 3 багийн 150 гаруй иргэн дээрх журмын төсөлд саналаа өгч, 500 гаруй иргэн ОНХС-ийн зарцуулалтын талаар мэдээллээр хангагдав.
20.	Хөвсгөл, Чандмань-Өндөр	Иргэдийн оролцоо-ОНХС	160 гаруй иргэн, ТББ оролцсон “ОНХС-д иргэний оролцоо” зөвлөгөөн зохион байгуулагдав.

ИТХ-ын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд гарсан зарим үр дүнгээс дурдвал:

- Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт нийт 97 хайгуулын лиценз олгогдсон байдаг байна. Тус сумын ИТХ “Байгаль орчныг хамгаалах

хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх нь” тэтгэлэг хэрэгжүүлж, уул уурхайн 15 компанид хяналт шалгалт хийжээ. Мөн “Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд иргэдийн оролцоо, эрх зүйн орчин” гарын авлага боловсруулж түгээжээ.

- Увс аймгийн Өндөрхангай сум нь 15-35 насны 1100 гаруй залуучуудтай. Суманд залуучуудын байгууллага, залуучуудад чиглэсэн бодлого байхгүй, идэвх оролцоо нь муу тул “Зөв бодлого-Залуучуудын хөгжил” сэдвээр тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлсэн. Тэтгэлгийн хүрээнд “Залуучуудын оролцоо манлайлал” сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн төсөл боловсруулж залуучуудаар хэлэлцүүлэн санал авч, ИТХ-аар баталсан байна.
- Налайх дүүргийн ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээнд тавих хяналтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлснээр 7 хорооны Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулж, ажиллах журмыг боловсруулжээ. Улмаар дүүргийн ИТХ-аас Олон нийтийн хяналтын зөвлөлүүдийн үйл ажиллагааг дэмжиж, 2020 оны төсөвт 19.8 сая төгрөгийг тусган шийдвэрлэжээ.

		
<i>Дорноговь аймгийн Даланжаргалан сум, хэлэлцүүлэг</i>	<i>Увс аймгийн Өндөрхангай сум, Залуучуудын хөгжлийн дэд хөтөлбөр батлах тухай ИТХТ-ийн тогтоол, 2019.12.03 №А/3</i>	<i>Налайх дүүрэг, Иргэдийн хяналт</i>

ИТХ-ын болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх, харилцан суралцах, туршлага, сургамжаа солилцох боломжийг бий болгох зорилготой Төрийн бус байгууллагын тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэв:


- 2019 оны төрийн бус байгууллагын тэтгэлэгт хөтөлбөрт 13 байгууллага санал ирүүлсэн бөгөөд бүтээлч шинэлэг аргачлал санал болгосон, цаашид үр дүн нь тогтвортой хэрэгжих боломжтой байх зэрэг шалгуурыг хангасан 6 байгууллага тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэхээр шалгарав.

№	ТББ	Саналын нэр	Хамтран ажилласан ИТХ
1.	Дархан НДЭХ	Нийтийн сонсголд суралцах нь 2	Дархан-Уул аймгийн Дархан сум Малчин баг
2.	Захиргааны шинэ санаачлага	Орон нутгийн төлөөллийн байгууллагын төсвийн хяналтын чиг үүргийг иргэдийн оролцоотой сайжруулах нь	Сүхбаатар дүүргийн ИТХ СБД-ийн 6 хорооны ИНХ
3.	МНУН	ИТХ-ын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, иргэдийн оролцоог хангах чиглэлээр шинэлэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь	Сүхбаатар дүүргийн хороодын ИНХ Баянгол дүүргийн ИТХ
4.	Монголын	Засаглалд залуучууд,	Булган аймгийн Сэлэнгэ сум

	хүүхдийн төлөө үндэсний төв	эмэгтэйчүүдийн оролцоо	ЧД-ийн 18-р хороо
5.	Тунгаамал төв	ИТХ-ын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, иргэдийн оролцоог хангах чиглэлээр шинэлэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь	Төв аймгийн ИТХ Төв аймгийн Баянчандмань сумын ИТХ
6.	Хил хязгааргүй алхам	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих чадавхыг сайжруулах нь	Дорноговь аймгийн Айраг сум, Айраг сумын 2-р багийн ИНХ

ТББ тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж, ИТХ-тай хамтран ажилласнаар:

- Нийтийн сонсголын болон иргэдийн оролцооны талаар чадавхжуулах сургалтад иргэд, Төлөөлөгчид хамрагдаж, Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор сумдад Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулагдаж, 110 гаруй иргэн оролцов. /"Дархан НДЭХ" ТББ/
- Сүхбаатар дүүргийн зарим хороодод ОНХС ба хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрт хяналт тавих Иргэдийн хяналтын бүлгүүд байгуулагдаж, ажиллах журам, аргачлал, стандарттай болов. Түүнчлэн дүүргийн хэмжээнд анх удаа Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулагдав. /"Захиргааны шинэ санаачлага" ТББ/
- Төслийн хүрээнд ИТХ-ыг иргэдийн үүсгэл санаачилгын бүлгүүдтэй холбох, идэвхжүүлэх үр дүнд хүрчээ. Ингэхдээ төслийн хүрээнд боловсруулсан "Төлөөлөгчийн манлайлал" сургалтын агуулга, арга зүйг ашиглан иргэдийн бүлгийн ахлагчдыг чадавхжуулсан байна. /Монголын нутгийн удирдлагын нийгэмлэг" ТББ/
- Булган аймгийн Сэлэнгэ сумын Залуучуудын зөвлөлийн үйл ажиллагаа идэвхжиж, оролцооны аргад суралцан, цаашид ИТХ-тай хамтран ажиллах төлөвлөгөө гаргав. /"Монголын хүүхдийн төлөө үндэсний төв" ТББ/
- Төв аймгийн болон Баянчандмань сумын ИТХ-ын үйл ажиллагаа, баталсан шийдвэрүүдийг судалж, "Үнэлгээ хийх аргачлал батлах", "Нийтийн сонсгол зохион байгуулах аргачлал батлах" тухай зэрэг иргэдийн оролцоог дээшлүүлэх зорилготой тогтоолуудыг аймгийн ИТХ баталсан байна. /"Тунгаамал төв" ТББ/
- Дорноговь аймгийн Айраг сумын Нард багийн ИНХ нь газар зохион байгуулалт, байгаль орчны асуудлыг хуралдаанаараа хэрхэн хэлэлцэн шийдвэрлэх аргачлалд суралцав. Баримт бичгийн шинжилгээ хийсэн дүнд үндэслэн тус ИНХ хуралдаан зохион байгуулах, баримтжуулах, архивлах талаар удирдамж, зөвлөмж, гарын авлага боловсруулсан байна. /"Хил хязгааргүй алхам" ТББ/




"Байгаль орчинд нөлөөлөл байдлын үнэлгээ ба Иргэний оролцоо" сургалт, Дорноговь аймгийн Айраг сумын Нард баг	"Дархан НДЭХ" ТББ-аас гаргасан гарын авлага	"МНУН" ТББ-ын тэтгэлгийн талаар мэдээлэл http://sukhbaatar.ub.khural
--	---	---

Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, сайн туршлагын талаар телевизийн нэвтрүүлэг, богино хэмжээний сурталчилгааны бүтээгдэхүүн боловсруулж, олон нийтийн хүртээл болгосноор иргэдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, ИТХ-ын сайн туршлагыг нийтэд түгээв.

- ИТХ-ын чиг үүрэг, үйл ажиллагаа, сайн туршлагын талаар мэдээлэл, сурталчилгааны бүтээгдэхүүн боловсруулах зөвлөх үйлчилгээг "Бага тугчин" ХХК гүйцэтгэж, дараах нэвтрүүлэг, шторкийг бэлтгэн олон нийтийн хүртээл болгов.

№	Нэвтрүүлгийн нэр	Агуулга	Хугацаа
1	"Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төсөл	"Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төслийн тухай	10 минут
2	"Нутгийн удирдлагын тогтолцоо, эрх зүйн шинэчлэл" чуулган	"Нутгийн удирдлагын тогтолцоо, эрх зүйн шинэчлэл" чуулган, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	10 минут
3	"Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төсөл	Хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулах чиглэлээрх Хан-Уул дүүргийн ИТХ-ын туршлага	10 минут
4	"Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төсөл	Нутгийн удирдлага иргэдтэйгээ хамтран ажиллаж, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж буй туршлага, Хэнтий аймгийн Баян-Овоо сум	10 минут
5	Богино хэмжээний сурталчилгаа	Багийн иргэдийн Нийтийн Хурлаар ямар асуудал шийдэж болох вэ?	40 секунд
		Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ямар асуудал шийдэж болох вэ?	40 секунд
		Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ямар асуудал шийдэж болох вэ?	40 секунд

- Шинэ санал санаачлага гарган, түүнийгээ орон нутагтаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа ИТХ-ын төлөөлөгч 4 эмэгтэйн сайн туршлагын талаар видео мэдээлэл бэлтгэн "Эмэгтэйчүүд манлайлал" чуулганы үеэр танилцуулав.
- Бусад эмэгтэй төлөөлөгчдөөс ирүүлсэн сайн туршлагыг нийтэд таниулах, сурталчлах зорилгоор монгол, англи хэлээр постер болгон бэлтгэж, www.khural.mn цахим хуудаст нийтлэв.



- Төслийн үр дүнд бий болсон сайн туршлага, сургамжийн талаар судалгаа хийх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулав. Тус зөвлөх үйлчилгээний хүрээнд ИТХ-аас тухайн орон нутагтаа санаачлан хэрэгжүүлж буй, иргэдийн амьдралд эерэг өөрчлөлт авчирсан үйл ажиллагаа, бодлого шийдвэр буюу сайн туршлагыг олж тогтоох, тэдгээрийг бусад ИТХ, иргэдэд сурталчлан таниулах сурталчилгааны бүтээгдэхүүний агуулга бий болох юм.
- Төслийн хүрээнд зохион байгуулагдсан үндэсний чуулган, бүсчилсэн болон хуулийн хэлэлцүүлэг, сургалт семинарын талаар мэдээ мэдээллийг тухай бүр бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар мэдээлж байв.

Бүх шатны 360 гаруй ИТХ-уудыг нэгтгэсэн www.khural.mn цахим хуудсыг иргэд, ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны ажилтнууд ашиглахад илүү хялбар, хэрэгцээнд нийцсэн болгох зорилготой системийн болон техникийн шинэчлэлт хийгдэж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэг орон даяар явагдсантай холбоотойгоор www.khural.mn цахим хуудаст шинэ цэс нээж, УИХ-ын цахим хуудастай шууд холбосноор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг ИТХ-ууд болон олон нийтэд танилцуулах сувгийг нэмсэн.

ИТХ-уудын нэгдсэн, портал цахим хуудас khural.mn нь 2014 оны 6 дугаар сард ашиглалтад орсноос хойш бүх шатны 361 ИТХ-ыг нэгтгэсэн, орон нутгийн мэдээллийн хамгийн том сүлжээ болон хөгжиж байна. Тус цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг хангахаар 2015 дугаар сард 5 сервер худалдан авч, Үндэсний дата төвд байршуулсан бөгөөд цахим хуудасны агуулга, нийтлэл, мэдээ мэдээллийн багтаамж ихэссэнээс техникийн хүчин чадлыг сайжруулах шаардлага бий болсон. Иймээс шинэ сервер худалдан авч, тус цахим хуудсыг хариуцан ажиллаж буй ЗГХЭГ-т хүлээлгэн өгөөд байна. Ингэснээр цахим хуудасны нэгдсэн портал системийн өгөгдлийг хадгалах серверийн ачаалал нэмэгдэж, ачаалах хугацаа удаашрах, алдаа гарах давтамж ихсэх зэргээр систем доголдох асуудал гарч бүрэн шийдвэрлэв.

www.khural.mn цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулав. Зөвлөх үйлчилгээ 2020 оны II улиралд багтаан хийгдэж, цахим хуудас ашиглалтад орно. Орон нутгийн дэд цахим хуудасны админуудын сургалт ирэх онд зохион байгуулагдана.

Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хооронд харилцан туршлага солилцох, хамтын ажиллагаагаа бэхжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж 5 удаагийн

бүсчилсэн хэлэлцүүлгийг ИТХ-уудтай хамтран зохион байгуулав. Үүний үр дүнд ИТХ-ууд үйл ажиллагаагаа илүү үр дүнтэй зохион байгуулах талаар сайн туршлагаасаа харилцан суралцав. Хэлэлцүүлэгт УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төлөөлөл оролцсон нь нутгийн удирдлагын эрх зүйн орчинд гарч буй сорилт бэрхшээл, шийдлийн талаарх орон нутгийн дуу хоолойг төрийн эрх барих дээд байгууллагуудын сонорт хүргэхэд чухал ач холбогдолтой байлаа.

Аймгуудын ИТХ-ын өөрсдийн санаачлагаар нутгийн өөрөө удирдах байгууллагууд харилцан туршлага солилцох, харилцаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой бүсчилсэн хэлэлцүүлгүүд зохион байгуулдаг уламжлалтай. Энэхүү тогтсон механизмыг түшиглэн төслийн хүрээнд ИТХ-уудтай хамтран ажиллаж, нутгийн удирдлагын чиглэлээрх хуулийн төслийн талаар танилцуулж саналыг нь авав.

- Зүүн бүсийн уулзалт 5 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд Хэнтий аймагт болов. Тус хэлэлцүүлэгт Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн ИТХ-ын дарга, тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ажлын албаны ажилтнууд оролцов. ЗГХЭГ-ын Орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын төлөөлөл оролцож, аймгуудын ИТХ-ын 2018 оны тайланд хийсэн дүн шинжилгээ, зөвлөмжийн талаар танилцуулав. Түүнчлэн Төслийн зохицуулагч төслийн хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаа, хүрсэн гол үр дүн, төслийн үлдсэн хугацаанд хийхээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөв.

Зүүн бүсийн уулзалтын тэмдэглэлээс:

...ЗЗНДНТУХ-ийг шинэчлэхтэй холбоотой хэлэлцүүлэг маш олон жил үргэлжиллээ. Үүнийг дуусгах хэрэгтэй. Хуульд нутгийн өөрөө удирдах ёсны биш, харин нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг оновчтой зөв тусгах...

Сүхбаатар аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан Жаргалсайхан

...Төрийн албан хаагчийн 30% квот үлдэх ёстой. Тухайн орон нутагтаа боловсролтой, нэр хүндтэй, сонгогдсоны дараа ажлаа хийх чадвартай хүмүүсийг сонгох ёстой. Тэгэхгүй бол төрийн захиргаа, удирдлагын талаар мэдлэг, боловсрол, туршлагагүй хүмүүс сонгогдохоор бодлого, үйл ажиллагаа нь болохгүй байна...

Хэнтий аймгийн ИТХ-ын тэргүүлэгч Жамбаа

- Төвийн бүсийн аймгуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлагаа хуваалцан бусад ИТХ-д түгээн дэлгэрүүлж сурталчилсанаар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагааны үр нөлөө, үнэлэмжийг нэмэгдүүлэх, ажлын албаны ажилтнуудын ажлын ур чадвар, арга барилыг дээшлүүлэх зорилготой уулзалт 5 дугаар сарын 22-25-ний өдрүүдэд Дорноговь аймагт болж, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Төв, Өмнөговь, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, ажлын албаны ажилтнууд зэрэг нийт 60 гаруй хүн оролцжээ. Чуулганаар аймаг, сумдын ИТХ-уудын ажлын уялдаа холбоог бэхжүүлэх, төр, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, хурлын байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулах, хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, иргэдийн оролцоог дэмжин ажиллах талаар аймаг бүр өөрсдийн туршлагын талаар танилцуулав. Мөн ИТХ-уудын ажлын үр дүнг үнэлэх

багц үзүүлэлтүүдийн талаар танилцуулга хийж, 2018 оны ажлын үр дүнгийн тайлан, зөвлөмж зэргийг хэлэлцэв.



Дорноговь аймаг, Төвийн бүсийн уулзалт
2019.05.22-25



Дархан-Уул аймаг, Төвийн бүсийн уулзалт
2019.09.05

- Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг УИХ-аар хэлэлцэж байсан үед буюу 9 дүгээр сарын 05-ны өдөр Дархан-Уул аймагт болсон уулзалтад УИХ-ын Тамгын газрын ажилтнууд оролцож, уг нэмэлт өөрчлөлт, түүний дотор нутгийн удирдлагын чиглэлээрх асуудлын талаар танилцуулж хэлэлцэв. Оролцогчид орон нутгийн төсөв, санхүүгийн бие даасан байдлыг хангах, төвлөрлийг сааруулах, төлөөлөгчдийг эгүүлэн татах, хариуцлага тооцох зэрэг асуудлын талаар сонирхож байсан бөгөөд бүсчилсэн болон үндэсний хэмжээний хэлэлцүүлэг, уулзалтын үеэр ИТХ-уудаас Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тусгах саналаа нэгтгэн өгдөг ч тэдгээр нь холбогдох хуулийн төсөлд тусгалаа олдог эсэх нь тодорхойгүй үлддэгийг шүүмжилж байв.
- Баруун бүсийн уулзалт 9 дүгээр сарын 12-13-ны өдөр Ховд аймагт болов. Энэ удаагийн хэлэлцүүлэгт Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан аймгийн ИТХ-ын дарга, ажлын албаны ажилтнууд болон УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын төлөөлөл оролцов. Баруун бүсийн ИТХ-ууд өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн ажил, сайн туршлагын талаар; УИХ-ын Тамгын газраас Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай; ЗГХЭГ-аас аймгуудын ИТХ-ын үйл ажиллагааны тайлагналтын талаар тус тус танилцуулав.



Ховд аймаг, Баруун бүсийн уулзалт, 2019.09.12-13



- Хангайн бүсийн уулзалт 9 сарын 29-30-ны өдрүүдэд Булган аймагт болов. Хангайн бүсийн ИТХ-уудын туршлага солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх уулзалт хэлэлцүүлэгт оролцов. Энэ удаагийн хэлэлцүүлэгт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга У.Бямбасүрэн болон Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтнууд

оролцож, сайн туршлагаа солилцов. Тухайлбал, Баянхонгор аймаг “Мини парламентийн үйл ажиллагаа, Чиг үүргийг оновчтой тодорхойлох, эрх зүйн судалгаа”, Булган аймаг “Иргэний танхимын үйл ажиллагаа”, Орхон аймаг “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хяналт-шинжилгээ үнэлгээ”, Өвөрхангай аймаг “Төлөөлөгчдийг тойрогт ажиллахад дэмжлэг үзүүлэх, нийтийн сонсгол”, Хөвсгөл аймаг “Галт санаачилга”, Архангай аймаг “ГХУСАЗСЗ-ийн хийж буй ажил” сэдвээр сайн туршлагаа танилцуулсан.



Булган аймаг, Хангайн бүсийн уулзалт, 2019.09.29-30

Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан орон нутгийн засаглал, нутгийн удирдлагын тогтолцоо хөгжсөн улс оронд ажиллаж, суралцсан туршлагад тулгуурлан тодорхой санал боловсруулж, ЗЗНДНТУХ-ийн шинэчилсэн найруулга, бусад хууль тогтоомжид тусгуулахаар хүргүүлсэн.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар туршлага судлах зорилгоор аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нар 6 дугаар сард Польш, Словак улсуудад ажиллав.

- Бүгд найрамдах Польш улсын нутгийн удирдлагын эрх зүйн орчин, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны туршлага судлах ажлыг 6 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд бүрэлдэхүүнд УИХ-ын Тамгын газар, ЗГХЭГ-ын төлөөлөл болон Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нар ажиллалаа. Туршлага судлах ажлын бэлтгэл зохион байгуулалтыг хангаж УИХ-ын Тамгын газрын удирдлага оролцогчидтой урьдчилсан уулзалт хийж, удирдамж чиглэл өгсний зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нутгийн удирдлагын тогтолцоо боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулах дэд ажлын хэсгийн гишүүн Ц.Товуусүрэн хуульд орох өөрчлөлтийн талаар мэдээлэл хийж санал солилцов. Тус туршлага судлах аялал нь Польш улсын нутгийн удирдлага, түүний зохион байгуулалт, орон нутгийн хөгжлийн бодлогыг төлөвлөх, захиргааны байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд нутгийн өөрөө удирдах байгууллагаас хяналт тавих чиг үүрэг, нутгийн удирдлагын байгууллагууд үндэсний түвшинд хамтран ажиллах талаар судалж, өөрийн практикт хэрэгжүүлэх санал, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллах зорилготой байлаа.



Зарим аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын Польш Улсын сайн туршлагаас суралцав. 2019.06.02-06

Туршлага судлах үеэр:

- Люблин хотод гадаад хамтын ажиллагааны төвийн захирал Кшыштоф Становски “Ардчилсан тогтолцоо руу шилжсэн шилжилт, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын шинэчлэл”-ийн асуудлаар;
- Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын төсөв санхүүгийн хэлтсийн дарга Мирослав Путон орон нутгийн төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт зарцуулалтын талаар
- Тус хотын боловсрол хүмүүжлийн асуудалд эрхэлсэн захирал Мирослав Ярлшински Боловсрол, соёлын салбар- орон нутгийг хөгжүүлэх бодлогын хөшүүргийн асуудлаар
- Иргэдийн оролцоо, нийгмийн асуудалд эрхэлсэн төвийн дэд захирал Анна Шадловска “Төсөв ногоон хөгжлийн төсөв” сэдвээр;
- Стратеги, безнис эрхлэлтийн газрын захирал Мариуш Саган Люблин хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар тус тус нар сургалт танилцуулга хийж хэлэлцүүлэг өрнүүлэв.

Тус улсын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажилд иргэд ихээр төсөл бичиж саналаа өгч улмаар төсөл нь дэмжигдвэл төсөл санаачлагч уг төслөөрөө санал асуулга явуулж, төслөө иргэдийн дунд сурталчилж ажилладаг бөгөөд иргэдээс хамгийн их санал авсан төсөл нь дэмжигддэг юм байна. Уг төсөлд нас харгалзахгүй оролцоно. Хүүхдүүд эцэг эхийн зөвшөөрлөөр оролцдог сайн туршлага байна. Хүүхэд залуучуудын дэвшүүлсэн саналыг дэмждэг тул хүүхэд залуучууд нийгмийн идэвхи сайтай болдог зэрэг сайн туршлагаас суралцлаа.

Говь-Алтай аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга А.Амарзаяагийн

Польш Улсад ажилласан Нарийн бичгийн дарга нар:

- Орон нутгийн бодлого, шийдвэр боловсруулахдаа иргэдийн /оршин суугчдын/ саналыг авдаг тусгайлсан орон тооны нэгж байгуулах /Иргэний оролцооны хэлтэс, Иргэний танхим/ гэх мэт
- иргэдийн дунд янз бүрийн сургалт, зөвлөгөөн зохион байгуулах /соён гэгээрүүлэх/
- иргэдийн идэвхи оролцоог хөгжүүлэх /пүрэв гаригийн өглөө бүр өглөөний цай зохион байгуулж иргэдээ сонсдог, хийх ажлын талаар санал сонсдог г. м/
- Иргэдийн санал санаачилга дээр үндэслэн Хотын хөгжлийн стратеги төлөвлөлтийг хийж хэрэгжүүлдэг
- Иргэдээс цахимаар санал авах

- Ногоон орчин, эко хүнс үйлдвэрлэдэг иргэд, аж ахуйн нэгжийг орон нутгийн зүгээс бодлогоор дэмжиж санхүүжилт олгох, урамшуулах тогтолцоог хэрэгжүүлэх
 - Аймгуудын соёлын төв, номын сангуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох иргэдийн оролцоо, санал дээр тулгуурласан үйл ажиллагаануудыг зохион байгуулах /иргэдийг хөгжүүлэх чиглэлээр/
 - ИТХ-аас санхүүг оновчтой төлөвлөх, төсвийн хяналтыг сайжруулах зэрэг өөрийн орон нутагт хэрэгжүүлэх боломжтой туршлагаа судласнаа тайландаа дурдсан байна.
- Бүгд Найрамдах Словак Улсад туршлага судлах аяллыг 2019 оны 6 дугаар сарын 16-21-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд бүрэлдэхүүнд ЗГХЭГ-ын төлөөлөл болон Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нар оролцов.



Словак улс, 2019.06.16-21

- Оролцогчдыг Кошиц хотын дэд дарга Гибода хүлээн авч уулзан хотынхоо хөгжил, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон төсвийн бүрдэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын чанартай томоохон төслийн санхүүжилт, Европын холбооны дэмжлэгийн талаар дэлгэрэнгүй танилцуулав.
- Бүсийн хурлын ажлын албаны газрын дарга нар уулзалт зохион байгуулж, Хурлын ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, Сонгуулийн хуулийн зохицуулалт, Бүсийн зөвлөлийн төсөв, хөгжлийн төслүүдийн хэрэгжилт, санхүүжилт, Бүсийн урт, богино хугацааны төлөвлөлт зэрэг асуудлаар мэдээлэл хийв.

Словак улс нь бүс нутгуудаа хөгжүүлэх программаа: 1. Бүсүүдийн ялгааг арилгах, 2. Орон нутгийн аж ахуйг хөгжүүлэх, 3. Ажилгүйдлийг арилгах гэсэн 3 чиглэлээр гаргасан байна. Эдгээр хөгжлийн бодлогоо бүсийн түвшинд хөрөнгө оруулалтын чиглэлээр, иргэний түвшинд зорилтот байдлаар ялгаатай боловсруулдаг нь онцлог санагдсан. Үндсэн хуулиндаа нутгийн удирдлагын байгууллагууд тэдгээрийн үйл ажиллагааны талаар нарийвчлан тусгаж, хэрэгжүүлэлтэнд тавих хяналт сайн байдаг юм байна.

Орхон аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Эрдэнэцэцэгийн тайлангаас

- Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын төлөөлөл 11 дүгээр сарын 27-29-ний өдрүүдэд Финланд улсад ажиллаж тус улсын нутгийн удирдлагын тогтолцоо,

орон нутгийн өмчийн харилцаа, Тогтвортой хөгжлийн зорилгыг бодлогод тусган ажиллаж буй талаар туршлага судлав. Туршлага судлах ажлын хүрээнд:

- Финландын орон нутаг, мужийн захиргаадын холбоо, нутгийн удирдлагын тогтолцооны талаарх танилцуулга, нутгийн захиргааны нэгжүүд (муниципалитет) өөр хоорондоо нэгдэн нийлэхтэй холбоотой хууль тогтоомж, журам, нутгийн иргэдэд сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд нутгийн захиргаадын (муниципалитет) ашиглаж буй хамтын ажиллагаа,
- Төв, орон нутгийн төсөв, санхүүгийн харилцаа; нутгийн захиргааны орон нутгийн өмчтэй холбоотой эрх хэмжээ; орон нутгийн өмчит компанийн удирдлага,
- Тогтвортой хөгжлийн зорилгыг төсөв бэлтгэх явцад тусгах, төв засгийн газар, орон нутгийн төсвийг тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулах,
- Кунтарекри буюу хүний нөөц бүрдүүлэх үйлчилгээг нийт улсын хэмжээнд хэрэгжүүлдэг орон нутгийн систем зэрэг асууудлаар мэдээлэл сонсож, хэлэлцүүлэг өрнүүлжээ.

Туршлага судлах ажлын үр дүнд орон нутгийн чиг үүрэг, санхүүжилт, орон нутгийн байгууллагуудын нийтлэг эрх ашгийг төлөөлөн төрийн эрх барих дээд байгууллагатай харилцах эрх бүхий субъектийг тодорхой болгох зэрэг Финланд улсын сайн туршлагыг ЗЗНДНТУХ-ийн шинэчилсэн найруулга, бусад хууль тогтоомжид тусгах саналыг дэвшүүлсэн байна.

Сорилт бэрхшээл, амжилтын хүчин зүйлс ба сургамж

- Төсөл хэрэгжиж эхэлсэнээс хойш буюу 2014-2019 оны хугацаанд ИТХ-ын үйл ажиллагааг дэмжих тэтгэлгийг нийт 6 удаа олгож, давхардсан тоогоор 102 ИТХ хамрагджээ. Тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлсэн ИТХ-ын 75,3 хувийг сумын ИТХ эзэлж байна. Сумын ИТХ-ын ажлын алба нь ихэвчлэн орон тооны нэг ажилтан (нарийн бичгийн дарга)-тай байдаг бөгөөд төсөл бичиж хэрэгжүүлэх, эрсдэл, боломжоо үнэлж, хүрэх үр дүнгээ тодорхойлох зэрэг чадавх, нөөц харилцан адилгүй, ихэвчлэн сул байгаа нь тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилтэд учирч буй томоохон сорилт байж ирсэн. Иймээс төслийн дунд хугацааны үнэлгээг хийсэн олон улсын зөвлөхүүдийн багаас өгсөн зөвлөмжийн дагуу энэ удаагийн тэтгэлэгт хөтөлбөрт төслийн хүрээнд бэлтгэгдсэн сургагч багш нарын дэмжлэгийг авч, сумын ИТХ-ын тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх боломжийг олгосон.
- ИТХ-ын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх багц үзүүлэлтийг боловсруулах ажил 2018 онд хийгдэж, шалгуур үзүүлэлтийн эхний загвар гарган ИТХ-ууд, ЗГХЭГ-ын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газарт танилцуулсан. Тус багц үзүүлэлтийг албан ёсны баримт бичиг болгож, ИТХ-уудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр ЗГХЭГ-ын дэмжлэгийг авахаар хүсэлт гаргасан.

Цаашид хийх ажил, тогтвортой байдал

- www.khural.mn цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлэх зөвлөх үйлчилгээ хийгдэж байна. Тус цахим хуудас нь анх ИТХ-ууд мэдээллээ солилцох, харилцан туршлага солилцох гол зорилготой байсан бол энэхүү зөвлөх үйлчилгээний хүрээнд нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй, ИТХ-ын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийн талаарх мэдээллийг авдаг гол талбар, эх сурвалж болгох чиглэлээр шинэчлэлт хийгдэнэ. Цахим хуудасны

шинэ хувилбар бий болж, ашиглалтад орсны дараа Админы сургалт зохион байгуулж, дэд цахим хуудсуудыг хариуцан ажиллах ажилтнуудыг бэлтгэнэ.

- Сумын ИТХ-ын үйл ажиллагаанд дэмжлэг болгох зорилгоор мэдлэгийн бүтээгдэхүүн/гарын авлага боловсруулж байна. 2020 оны эхний улиралд гарын авлагыг хэвлэж ИТХ-уудад хүргэнэ.
- ИТХ-ын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх багц үзүүлэлтийг албан ёсны баримт бичиг болгож, ИТХ-уудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр ЗГХЭГ-тай хамтран ажиллана.
- ИТХ-ын жишиг дэгийг аймаг, сум, дүүргийн ИТХ-ын үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар үргэлжлүүлэн ажиллана.
- ЗЕХ-ийн хялбаршуулсан гарын авлагыг аймаг, сум, дүүргийн ИТХ-уудад хүргэх, чадавхыг бэхжүүлэх талаар ажиллана.
- Аймаг, сум, дүүргийн ИТХ-уудын шинэлэг санаачилгыг дэмжих зорилготой тэтгэлэгт хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Удирдлагын академийн дэргэд шинээр байгуулагдах Нутгийн удирдлагын сургалт, судалгаа, мэдээллийн төвөөр дамжуулан ИТХ-уудын сайн туршлагыг баримтжуулах, түгээх, харилцан суралцахад нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллана.

Төслийн үр дүнгийн хүснэгт /Хүрэх Үр дүн 2-ын хүрээнд/

Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт		Зорилт	2019 онд хүрсэн түвшин	2017-2019	Мэдээлэл, нотолгооны эх сурвалж
2.1. Үлгэрчилсэн дэгийг батлан мөрдүүлж байгаа Хурлын хувь хэмжээ	0	2016	20% он1 30% он2 40% он3 50% он4	Төслийн үндэсний захирлаас бүх шатны ИТХ-д албан ёсоор хүргүүлсэн.	Хэрэгжиж буй. Аймаг: 23,8 хувь Сум: 18,8 хувь Ихэнх ИТХ орон нутгийн сонгуулийн дараа буюу шинэ ИТХ-ын бүрэн эрх хэрэгжиж эхлэхэд хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.	www.khural.mn Төслийн хүрээнд авсан судалгаа
2.2. Хууль, эрх бүхий дээд байгууллагын шийдвэртэй зөрчилдсөн ИТХ-ын шийдвэрийн тоо	97	2013-2014	0	0	Биелэгдсэн. 0 ЗЕХ-ийн хуулийн дагуу зөрчилтэй хэмжээний акт улсын бүртгэлд бүртгэгдээгүй. 2019: ХЗДХЯ-нд бүртгүүлэхээр ирүүлсэн- 278 Үүнээс бүртгэгдсэн- 230 шийдвэр	www.legalinfo.mn ХЗДХЯ
2.3. Хурлын хяналтын чиг үүргийн хүрээнд гаргасан бодлогын санал зөвлөмжийг хүлээн авсан хувь хэмжээ	0	2016	70%		Хэрэгжиж буй. 2020 оны 6 сард ИТХ-уудаас судалгаа авч, мэдээллийг шинэчлэнэ.	Тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилтийн болон мониторингийн тайлан
2.4. www.khural.mn цахим хуудаст нийтлэгдэж буй хурлын	-	2016		Хэсэгчлэн биелэгдсэн. <i>*Аймгийн ИТХ:</i> хурлын тэмдэглэл - 61.9%; <i>Орон нутгийн төсөвтэй холбоотой мэдээлэл - 100%;</i>		Төслийн нэгжээс хийсэн судалгаа

шийдвэрийн хувь хэмжээ (аймаг, сум, дүүргээр)				Хурлын тогтоол, шийдвэр - 100%; <u>Сумын ИТХ</u> : хурлын тэмдэглэл - 38.1%; Орон нутгийн төсөвтэй холбоотой мэдээлэл - 90.9%; Хурлын тогтоол, шийдвэр - 58.7%; <u>Дүүргийн ИТХ</u> : хурлын тэмдэглэл - 25%; Орон нутгийн төсөвтэй холбоотой мэдээлэл - 100%; Хурлын тогтоол шийдвэр- 100%;	
2.5. Үр дүнгийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг ашиглаж буй хувь хэмжээ	0	2016	100	Үр дүнгийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн загварыг боловсруулж, бүх шатны ИТХ-д хүргүүлсэн.	Хэрэгжиж буй. ИТХ-аас ЗГХЭГ-т хүргүүлдэг тайланг тус загварын дагуу ирүүлэхийг зөвлөмж болгосон.
					ЗГХЭГ-т ирүүлж буй ИТХ-ын тайлан

ХҮРЭХ ҮР ДҮН 3: ОРОН НУТГИЙН СОНГОГДСОН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙНГЫН МЕХАНИЗИМТАЙ БОЛОХ

2019 онд хүрсэн үр дүн, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид манлайллын сургалтаар олж авсан мэдлэгтээ тулгуурлан санаачлан хэрэгжүүлсэн ажлуудыг сайн туршлагын эмхтгэл болгон хэвлэж түгээсэн нь бусад эмэгтэй төлөөлөгчдөд шинэ сэдэл, урам зориг төрүүлж байна.

Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтыг 2018 онд “МонФемНет” үндэсний сүлжээ хариуцан зохион байгуулсан. Энэ сургалтын гол үр дүн нь сургалтын дараа төлөөлөгчидтэй байнгын эргэх холбоотой ажиллаж, тэднийг зөвлөгөө мэдээллээр хангахын зэрэгцээ, хийж хэрэгжүүлсэн санаачлага, сайн туршлагыг нь цуглуулж баримтжуулан авч үлдэж, түгээн дэлгэрүүлж байгаагаараа онцлог бөгөөд цогц үйл ажиллагаа болсон.

Сургалтын дараа эмэгтэй төлөөлөгчдийн санаачлан хэрэгжүүлсэн ажлын талаар “МонФемНет” үндэсний сүлжээ аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын ажлын албаны дэмжлэгтэйгээр мэдээлэл цуглуулсан. Төслийн зүгээс LOGIN сүлжээ байгууллагын зөвлөх багшийг урьж “Харилцан суралцах арга зүй”-н талаар чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулсан бөгөөд үүний үр дүнд ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлагуудаар эмхэтгэл боловсруулж гаргав.



Тус эмхэтгэл нь иргэдийг төлөөлж сонгогдсоны хувьд хуралдаанд оролцож, санал өгөх төдийгөөр үүргээ хязгаарлалгүй нутгийн иргэдийн өмнө тулгамдсан тодорхой асуудлыг олж харж, олон нийт, шийдвэр гаргагчдын анхааралд авчирч, бодлогын түвшинд гарган тавьж, шийдэхийн төлөө тууштай зүтгэж буй эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хувь нэмрийг баримтжуулах, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх, танигдахад нь дэмжлэг болох юм.

Сонгогдсон төлөөлөгчдийн хэрэгцээний судалгаанд үндэслэн Удирдлагын академийн боловсруулж, зохион байгуулсан сэдэвчилсэн сургалтад 21 аймгийн ИТХ өөрийн ажлын албаны ажилтнууд, сумдын ИТХ-ын тэргүүлэгчдээ хамруулахаар саналаа ирүүлж, 51.4 сая төгрөгийг өөрсдийн төсвөөс санхүүжүүлсэн нь орон нутгийн төсвөөс сургалтын зардлыг санхүүжүүлэх замаар “...сургалтын хөтөлбөрүүдийг цаашид тогтвортой үргэлжлүүлэн хэрэгжүүлэх...” төслийн зорилтод хүрэх чухал алхам болов.

Удирдлагын академитай 2017 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах суурь сургалтын хөтөлбөр, менежментийг Академи хариуцан авсан. Энэ хүрээнд 2018 онд сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах хэрэгцээний судалгаа хийгдэж, Төлөөлөгчдийн суурь сургалтаар олгогдсон мэдлэгийг практикт хэрэгжүүлж, бататгах сургалтын хөтөлбөр боловсруулсан. Төслийн хүрээнд зохион байгуулагдсан өмнөх сургалт, семинарын үеэр авсан санал асуулга, судалгааны дүнгээс харахад ИТХ-ын Ажлын албаны ажилтнуудыг сургалтад хамруулах, чадавхжуулах хэрэгцээ шаардлага байгаа нь харагдсан.

...Эдгээр модуль сургалтыг ИТХ-ын төлөөлөгч, Ажлын албаны ажилтнуудад хүргэхэд 2019 онд аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-тай хамтран ажиллах, Удирдлагын академийн сургалтын албан ёсны хөтөлбөрт тусгахаар зорьж байна...

*“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь”
төслийн 2018 оны ажлын тайлан, 28-р хуудас*

Удирдлагын академийн Мэргэшил дээшлүүлэх институттэй хамтран Хууль тогтоомжийн хэрэглээ; Орон нутгийн төсвийг төлөвлөх, хянахад ИТХ-ын гүйцэтгэх үүрэг; Байгаль хамгаалал, газрын харилцаа- ИТХ-ын болон иргэдийн оролцоо; ИТХ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ; ИТХ-аас гарах шийдвэрийн төсөлд хийх дүн шинжилгээ гэсэн 5 сэдвийн хүрээнд 18 цагийн сургалт зохион байгуулав.


Сургалт нь ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны ажилтнуудад ИТХ-ын хяналт шинжилгээ хийх, холбогдох хууль тогтоомжийн хэрэглээ, орон нутгийн төсвийн төлөвлөлт болон орон нутгийн байгаль хамгаалал, газрын харилцаанд иргэдийн оролцоог хангах мэдлэг чадвар эзэмшүүлэхэд зорилготой.

Мөн өмнө нь чадавхжуулах сургалтыг ИТХ-ын төлөөлөгчдийн хүрээнд зохион байгуулдаг байсан бол энэ удаад ажлын албаны ажилтнуудыг хамруулахад түлхүү анхаарлаа.

Оролцогчдоос авсан судалгаанд дараах гол мэдлэг чадварыг сургалтаас олж авсан гэжээ:

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар мэдлэг дээшилсэн.

- Орон нутгийн төсвийг төлөвлөх, хянахад ИТХ-ын гүйцэтгэх үүрэг, ИТХ-ын шийдвэрийн төсөлд хийх дүн шинжилгээ, хяналт, шинжилгээ, үнэлгээ
- Үндсэн хуулийг хэрхэн хэрэглэх талаар болон орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавих талаар чухал мэдлэг олж авсан
- Хууль хэрэглэх, хэрэгжүүлэх
- ИТХ-ын шийдвэр гаргах процесс, түүнийг үнэлэх болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авлаа.



Оролцогчид сэдвийн агуулгын хувьд “ИТХ-ын хяналт, шинжилгээ үнэлгээ” сэдвийг, заах арга зүйн хувьд мөн дээрх болон орон нутгийн төсвийн сэдвийг өндрөөр үнэлсэн байна.



Сургалтад 21 аймгийн аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч, Ажлын албаны ажилтнууд нийт 320 хүн хамрагдаж, аймаг, сумдын ИТХ 51,4 сая төгрөгийг

өөрсдийн төсвөөс санхүүжүүлсэн нь сургалт эрэлт хэрэгцээтэй байсны илэрхийлэл гэж үзэж байна.

Зарим сумдын ИТХ-аас төлөөлөгчдийнхөө суурь сургалтаас олж авсан мэдлэг чадварыг бататгах, сайн туршлага солилцох санал санаачлага гаргасны дагуу 11 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд “Орон нутгийн төсвийн удирдлага, хяналт, тогтвортой хөгжил”, “Төлөөлөгчийн манлайлал” сургалт семинар зохион байгуулав. Тус сургалтад 300 орчим төлөөлөгч оролцсон бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийн нутгийн удирдлагатай холбоотой зохицуулалт, хүнс хөдөө аж ахуйн салбарт төрөөс явуулж буй бодлого, Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтэд сумын ИТХ-ын үүрэг зэрэг сэдвээр мэдээлэл сонсож, сайн туршлагаа тодорхойлох, хэрхэн хамтаараа манлайлах арга барил, чадварт суралцав.



Зүүн болон өмнөд Азийн 12 орныг нэгтгэсэн LOGIN нутгийн удирдлагын сүлжээ байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлж, гишүүн орнуудын сайн туршлага, эрдэмтэн судлаачдын мэдлэгийг өөрийн улсын нутгийн удирдлагын болон төрийн бус байгууллагуудад нэвтрүүлж байна.

LOGIN Asia буюу “Нутгийн удирдлагын санаачлага, сүлжээ” зүүн болон өмнөд Азийн 12 орны сургалтын институт, сонгогдсон төлөөлөгч, засгийн газрын холбогдох нэгж, төрийн бус байгууллагуудыг нэгтгэсэн томоохон байгууллага юм. Тус байгууллага нь 2013 онд байгуулагдсан бөгөөд Швейцарын хөгжлийн агентлаг дэмжлэг үзүүлдэг. Нутгийн удирдлагын байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн төвлөрлийг сааруулах, иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зэрэг чиглэлээр харилцан суралцах, туршлага хуваалцах, мэдлэгийн бүтээгдэхүүн гаргах үйл ажиллагаа явуулдаг.

Манай аймгийн сумын ИТХ-ууд сайн туршлага солилцох уулзалт зохион байгуулахад би уулзалтыг хөтөлж явуулах хүсэлт гаргаж, Харилцан суралцах арга зүйгээр явуулсан нь их сонирхолтой, үр дүнтэй болсон. Аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтнууд ихэд сонирхож, дараагийн зохион байгуулах уулзалт семинартаа энэ аргыг ашиглана гэсэн. Би энэ арга зүйг ШХА-ийн нэгэн төслөөс LOGIN байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалтаас суралцсан юм.

А.Даваажаргал, Увс аймгийн Өндөрхангай сумын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга

LOGIN Asia байгууллагатай хамтран “Харилцан суралцах арга зүй” сургалтыг 2 дугаар сард зохион байгуулж, “МонФемНет” ТББ болон аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нар хамрагдав.

- 2019 оны 2 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд НҮБ-ын байранд “МонФемНет” ТББ-ын сургагч багш нарыг хамруулсан сургалтыг LOGIN Asia байгууллагын зөвлөх Шантану Лахир хөтлөн явуулав. Энэ сургалтын гол онцлог нь өөрийн сайн туршлагыг бусдад түгээн дэлгэрүүлэх, хамтран ажиллагчдын дунд талархалтай, харилцан хүндэтгэсэн харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтын шинэ арга юм. “МонФемНет” ТББ-тай хамтран 2018 онд зохион байгуулагсан эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалтад ажилласан сургагч багш нар энэ удаагийн сургалтад оролцсон бөгөөд эмэгтэй төлөөлөгчдийн санаачлан хэрэгжүүлж буй сайн туршлагыг баримтжуулан цуглуулснаа сургалтын үеэр танилцуулсан.




Харилцан суралцах арга зүй сургалт, НҮБ-ын Төв байр, 2019.02.17-18

- 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдөр болсон аймаг, дүүргийн ИТХТ-ийн нарийн бичгийн дарга нарын уулзалт семинарын үеэр ИТХ-уудыг чадавхжуулахад харилцан суралцах арга зүйг ашиглах талаар Удирдлагын академийн багш Я.Бямбасүрэн танилцуулав. Сургалтын агуулгатай холбогдуулан Нарийн бичгийн дарга нар өөрийн ИТХ-ын сайн туршлагаас тус бүр нэгийг онцлон ярьж, танилцуулан, бусад хурал тухайн туршлагаас хэрхэн суралцах дадлага ажил хийлээ.



Аймаг, дүүргийн ИТХТ-ийн нарийн бичгийн дарга нарын уулзалт семинар
НҮБ-ын Төв байр, 2019.03.01

- 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдөр зохиогдсон “Эмэгтэйчүүд манлайлал” үндэсний чуулганд LOGIN Asia байгууллагын төлөөлөгчид оролцож, харилцан суралцах арга зүйг ашиглан боловсруулсан сайн туршлагаудтай танилцав.



Сургагч багш нарын дэмжлэгтэйгээр сумын ИТХ, багийн ИНХ-ыг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын үр дүнг бататгаж, практикт хэрэгжүүлэхэд нь зөвлөн туслав. Үүний үр дүнд сумын төдийгүй багийн ИНХ төслийн хүрээнд боловсруулсан хуралдааны үлгэрчилсэн дэгийн дагуу хурлын дэгээ шинэчлэн баталлаа. Төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтуудын үр дүнд орон нутгийн түвшинд гарч буй өөрчлөлт, сайн туршлагын талаар баримт мэдээлэл нэмэгдлээ.

Төслийн хүрээнд 21 аймаг болон нутгийн удирдлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын бүрэлдэхүүнээс 62 сургагч багш бэлтгэж, эдгээр багш нар Төлөөлөгчдийн суурь сургалтын агуулгыг хүргэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ онд Сургагч багш нарын мэдлэг, туршлагыг ашиглан практикт буюу сум, багийн хуралд очиж биечлэн арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж, аймгуудын ИТХ-тай 2019 оны 9 дүгээр сард Хамтран ажиллах гэрээ байгуулсан.



Сэлэнгэ аймгийн Шаамар сум



Завхан аймгийн Дөрвөлжин сумын
Буурал баг



Төв аймгийн Баянчандмань сум

Сум, багийн хурлыг чадавхжуулах энэ үйл ажиллагаанд нийт 19 аймгийн 51 сумын ИТХ, 102 багийн ИНХ хамрагдаж, дараах чиглэлээр чадавхжив:

■ Сумын ИТХ:

- Сургагч багш нар www.khural.mn цахим хуудасны ашиглалтад дүн шинжилгээ хийж, зөвлөмж өгөв. Тухайн сумын ИТХ-ын дэд цахим хуудаст нийтэлсэн мэдээ, мэдээлэлтэй танилцан, үүсдэг бэрхшээлийг тодорхойлох, анхаарах асуудлын талаар санал дүгнэлт гаргах ажлууд хийлээ. Тухайлбал, зарим сумдын хувьд админы сургалтад хамрагдсан ажилтан нь өөр ажилд шилжсэн, интернетийн хурд удаан, хэвлэмэл материал, фэйсбүүк хуудас ашиглан иргэдэд мэдээллээ хүргэдэг зэрэг шалтгаанаар цахим хуудасны хөгжүүлэлт хийгддэггүй байна. Сургагч багш нар дэд цахим хуудаст дүн

шинжилгээ хийсэн нь эдгээр 50 гаруй сумын ИТХ-д www.khural.mn дэд цахим хуудсыг хөгжүүлэх идэвх, санаачлагыг төрүүлснээрээ ач холбогдолтой болов.

- ИТХ-ын хуралдааны дэгд шинжилгээ хийж, төслийн хүрээнд боловсруулсан үлгэрчилсэн дэгийн талаар төлөөлөгчдөд мэдээлэл, танилцуулга хийв. Сумын ИТХ өөрийн хуралдааны дэгийг үлгэрчилсэн дэгтэй харьцуулан судалж, дэгээр зохицуулагдаагүй үлдсэн асуудлыг олж харсан нь энэ ажлын нэг үр дүн байв. Тухайлбал, дараах асуудлууд сургагч багш нарын тайланд дурдагджээ.
 - Архангай аймгийн Хотонт сум - хуралдаан бүрт дэг баталдаг,
 - Баянхонгор аймгийн Галуут сум - нөхөн сонгууль болсон тохиолдолд шинэ төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх хугацааг заагаагүйгээс цаг алддаг,
 - Баянхонгор аймгийн Шинэжинст сум - Хуралдаан зохион байгуулах газрыг тусгаагүйгээс маргаан гарч байсан.

Тус чадавхжуулах үйл ажиллагаанд хамрагдсан 51 сумын 22 нь буюу 43.1 хувь нь 11-12 дугаар сард болсон хуралдаанаараа дэгээ шинэчлэн баталсан байна.

- Төлөөлөгчид сургалтаас олж авсан мэдлэгээ хэрхэн ашиглаж байгаа, сургалтын үр дүнд гарсан ахиц дэвшил, онцлог содон үйл ажиллагааг баримтжуулав. Сургагч багш нар сумдад ажиллах хугацаандаа ажиглалт хийх, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, санал асуулга авах зэрэг аргаар сургалтын үр дүнг үнэлэхийг зорьжээ. Тухайлбал,
 - Дорноговь аймгийн Сайхандулаан суманд ажилласан сургагч багш сумын төвөөр нэг цагийн хугацаанд явж гудманд явсан 18 иргэнээс ИТХ-ын талаарх ойлголт, хэрэгжүүлж буй үйл ажиллагааных нь талаар тандан судалжээ. Ингэхэд 46.2 хувь нь сайн, 13 хувь нь хангалтгүй, 15 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.
 - Дархан-Уул аймагт ажилласан сургагч багш төлөөлөгчидтэй бүлгийн ярилцлага хийжээ. Ярилцлагын үеэр “төлөөлөгчдийн идэвхи, оролцоо чадавхжуулах сургалтын дараа сэргэж, бусад үед буурах хандлагатай байдаг тул сургалтын хугацааг ойртуулж, давтамжийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Мөн сургалтаас гадна туршлага солилцох ажил чухал” гэсэн саналууд гарсан байна.

...Өмнөх жилүүдэд төсөв батлах үед Засаг дарга нарын өргөн мэдүүлсэн төсвийн тоог учрыг нь олохгүйн улмаас зөвхөн гар өргөж, аялдан дагадаг байсан бол одоо олон талаас нь хэлэлцэж баталдаг болжээ. Засаг дарга нар ч төлөөлөгчдийн тавьсан асуулга, саналд ач холбогдол өгч хандах болсон байна...

Дорнод аймагт ажилласан сургагч байгшийн тайлангаас

- Багийн ИНХ:
 - ИНХ-ын хуралдаанд оролцогчдын ирц, идэвхийг нэмэгдүүлэх шинэлэг арга барил ашиглах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх санал зөвлөмж өгөв.

- Баримт бичгийн шинжилгээ хийж, боловсруулалтыг сайжруулах арга зүйн зөвлөмж өгөв.
- Хуралдааны явцад үндэслэн дэгийг боловсронгуй болгох санал боловсруулж танилцуулав. Тухайлбал, Баянхонгор аймгийн сургагч багш нар очиж ажилласан багтаа дэгийг хэрхэн батлах, ямар асуудалд анхаарах талаар зөвлөмж өгч хэлэлцүүлэг зохион байгуулжээ. Энэ үйл ажиллагаанд хамрагдсан 4 багийн ИНХ “Багийн ИНХ-ын дэгийн тухай” тогтоол баталсан байна.

...Багийн ИНХ-ын үйл ажиллагааг сайжруулах талаар аймаг, сумын ИТХ-аас тогтмол, системтэй ажил зохион байгуулах шаардлагатай байгаа нь харагдлаа. Аймгийнхаа бүс бүрээс нэг баг сонгон авч дэмжлэг үзүүлж, түүнд тулгуурлан бусад багийн дарга нарт үзүүлэх сургууль хийх ажлыг зохион байгуулахаар төлөвлөгөөндөө орууллаа...

Булган аймгийн сургагч багшийн тайлангаас

Эдгээрээс харахад төслийн сургагч багш нарыг орон нутагт ажиллуулж, сумын ИТХ, багийн ИНХ-уудад практик үйл ажиллагааны зөвлөмж өгч газар дээр нь очиж ажилласан нь нутгийн өөрийн удирдлагын анхан шатны эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд чухал хэрэгтэй санаачилга боллоо. Сургагч багш нарын хувьд ч мөн адил заасан хичээлийнхээ үр дүнтэй танилцах, цаашид сургалт явуулбал юуг анхаарах тал дээр дүгнэлт хийж, шинэ сэдэл, санаа төрүүлсэн арга хэмжээ болов.

Нутгийн удирдлагын байгууллагууд харилцан туршлага солилцох лаборатори, орон нутгийн удирдлага, сайн туршлагын талаарх судалгаа, мэдээллийн бааз, төв орон нутгийг холбосон бодлогын хэлэлцүүлгийн талбар болж хөгжих Нутгийн удирдлагын сургалт, судалгаа, мэдээллийн төвийг байгуулах эхний алхмыг хийлээ.

Төслийн хүрээнд бий болсон үр дүнгийн тогтвортой байдлыг хадгалан үлдэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Удирдлагын академи хооронд 9 дүгээр сарын 12-ны өдөр Хамтран ажиллах гэрээ байгуулав. Гэрээний дагуу Удирдлагын академийн дэргэд Нутгийн удирдлагын сургалт судалгаа, мэдээллийн төв байгуулагдаж буй бөгөөд энэ төв нь нутгийн удирдлагын чиглэлээр судалгаа мэдээллийн бааз бүрдүүлэх, сургалт судалгааны хөтөлбөр, агуулга бий болгох, хурал болон төлөөлөгчид хариуцан туршлага судлах боломжийг нээх зэрэг үйл ажиллагааг хариуцан ажиллаж, тодорхой үр дүнд хүрэх юм. Төвийн байрыг тохижуулах, техник, тоног төхөөрөмжөөр хангах ажил энэ онд хийгдлээ.

Сорилт бэрхшээл, амжилтын хүчин зүйлс ба сургамж

- Аймгийн ИТХ-аас төлөөлөгчид, ажлын албаны ажилтнуудаа чадавхжуулах сургалтад хамруулах санал санаачлага гаргаж, зардлын тодорхой хэсгийг хариуцсан нь сургалтын агуулгын эрэлт хэрэгцээг харуулахын зэрэгцээ дээрх зорилгоор орон нутаг тодорхой төсвийг зориулах хүсэл сонирхол, боломжтой байгааг харууллаа. Түүнчлэн сонгогдсон төлөөлөгчдийн төдийгүй Ажлын албаны ажилтнуудаа сургахад түлхүү санаа тавьж, анхаарч байгаа нь сайшаалтай байна.

- Төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй аливаа сургалт (бусад арга хэмжээ)-нд оролцох нийслэл, дүүргийн ИТХ-ын Төлөөлөгчдийн ирц, идэвх бага байв. “Нутгийн удирдлагын байгууллагын талаарх иргэдийн ойлголт мэдлэгийн судалгаа”-ны дүнгээс харахад ИТХ-ын талаар иргэдийн ойлголт, мэдлэгийн түвшин аймаг, сумдад өсөж, нийслэл, дүүрэгт буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь нийслэл, дүүргийн ИТХ-ууд иргэдэд чиглэсэн үйл ажиллагаагаа идэвхжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.
- ИТХ-ууд чадавхжуулах үйл ажиллагааг сайн туршлагаа хуваалцах, харилцан суралцах байдлаар хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байгаа нь санал асуулга, судалгаануудаас харагдаж байна. Энэ нь ИТХ-ууд өөрийн өвөрмөц онцлог бүхий шинэ санал санаачлага гарган ажиллаж байгаа, түүнийг нь бусад хурлууд үнэлж, суралцах, нэвтрүүлэхийг зорьж байгаагийн илрэл гэж үзэж болох юм. Иймд цаашид сайн туршлагуудыг баримтжуулах, сурталчлах талаар төсөл анхаарч, хөрөнгө нөөц хуваарилах хэрэгтэй байна.
- Нутгийн удирдлагын чиглэлээр ИТХ-ууд харилцан суралцахаас гадна энэ чиглэлээрх олон улсын байгууллага, бусад улс орноос туршлага судлах, суралцах боломж бий болж байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн чуулган олон улсын шинжтэй болсон (Швейцар, Энэтхэг, Бутан), МонФемНет ТББ ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг The Hunger Project байгууллагатай хамтын ажиллагаагаа эхлүүлсэн зэргийг дурдаж болно.
- Дээрх ололт амжилт гарч байгаа хэдий ч ИТХ-ууд сайн туршлага, үйл ажиллагаа, үр дүнгээ олон нийтэд сурталчлан таниулах боломж, чадвар сул хэвээр байна. Иймд ИТХ-уудыг энэ чиглэлээр чадавхжуулахад төслөөс анхаарал хандуулж, дэмжих шаардлагатай байна.

Цаашид хийх ажил, тогтвортой байдал

- Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлагыг цуглуулах, баримтжуулах ажил үргэлжилнэ.
- Төслийн хүрээнд зохион байгуулагдсан сургалт, бусад үйл ажиллагааны үр нөлөөний хөндлөнгийн судалгаа, нутгийн удирдлагын байгууллагын талаар иргэдийн ойлголт мэдлэгийн судалгаа, ИТХ-уудын сайн туршлагыг судлан баримтжуулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Тус зөвлөх үйлчилгээнүүдийн эцсийн үр дүн 2020 оны эхний улиралд бэлэн болно.
- Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлэгт орсон нэмэлт, өөрчлөлт болон холбогдох бусад хууль тогтоомжид орох нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын гарын авлагыг шинэчлэн боловсруулж, сургагч багш нарын сургалтыг зохион байгуулна.

Төслийн үр дүнгийн хүснэгт /Хүрэх Үр дүн 3-ын хүрээнд/

Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт/он		Зорилт	2019 онд хүрсэн түвшин	2017-2019	Мэдээлэл, нотолгооны эх сурвалж
3.1.Төлөөлөгчдийн суурь сургалтад хамрагдсан хувь	59%-орон нутагт; 86.5% хотод	2014	85% хотод; 95% Орон нутагт	Суурь сургалтыг орон нутгийн сонгуулийн дараа буюу төслийн эхний жил зохион байгуулсан.	Биелэгдсэн. Ирцийн хувь: 85% хотод; 95% орон нутагт; эрэгтэй 73.7% эмэгтэй 26.3%	Төслийн нэгжид ИТХ-уудаас ирүүлсэн сургалтын тайлан

3.2.Манлайлал, шийдвэр гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнээс ашиг хүртсэн эмэгтэйчүүдийн тоо	1800	2015	1000	Эмэгтэйчүүдийн манлайлал сургалтын гарын авлага 2018 онд шинэчлэгдсэн; Эмэгтэйчүүдийн манлайлал сургалтад хамрагдсaдын тоо - 1,858	Биелэгдсэн. Сургалтад хамрагдагсад- 1,858; 60 эмэгтэй төлөөлөгч амжилтын түүхээ хуваалцсан. Эмэгтэй төлөөлөгчдийн чуулганд 400 эмэгтэй оролцсон.	Чуулганы болон сургалтын бүртгэл		
3.3.Сургалтаас олж авсан ур чадвараа ажил үүргээ хэрэгжүүлэхэд ашиглаж буй төлөөлөгчдийн хувь хэмжээ	80%	2015	-	Биелэгдсэн. Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр нөлөөний судалгаа 2019 оны эцэст хийгдсэн. Төлөөлөгчдийн 80 хувь сургалтаас олж авсан чадвараа ашигладаг гэж хариулсан: Суурь сургалт: эмэгтэй 62.6%, эрэгтэй 56.3%, манлайллын сургалт: эмэгтэй 84.01%, эрэгтэй 84.2%, Эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалт 89.7%.		Сургалтын үр нөлөөний үнэлгээ (2019-2020)		
3.4.Төлөөлөгчдөд зориулсан сэдэвчилсэн сургалтын агуулга, тоогоор	3	2016	3	Биелэгдсэн. Төлөөлөгчдөд зориулсан сэдэвчилсэн сургалтын агуулгын тоо – 6;		Удирдлагын академи боловсруулсан.		
3.5.Сургагч багш нарын сүлжээг өргөтгөж, дэмжлэг үзүүлсэн байдал	52	2016	100	Биелэгдсэн. Сургагч багш нарын тоо – 117; (62 суурь сургалт, 25 манлайллын сургалт, 22 эмэгтэй төлөөлөгчдийн сургалт, 8 Удирдлагын академи)		Төслийн нэгжийн сургагч багш нарын бүртгэл;		
3.6.Хурлаас сургалтад зориулан гаргаж буй санхүүжилт	0	2016	-	Хэрэгжиж буй. Манлайллын сургалтын зардлыг 10 аймаг хамтран санхүүжүүлсэн. - \$26,000; Бататгах сургалтын зардлыг 21 аймаг хамтран санхүүжүүлсэн. - \$31,300		Аймгуудын тайланд үндэслэсэн Төслийн нэгжийн тооцоолол(2019);		
3.7.Төлөөлөгчдийн талаарх иргэдийн ойлголт мэдлэг	50%	2015	60%				Иргэдийн ойлголт мэдлэгийн судалгаа (2019-2020)	
					2019	2015		Өөрчлөлт
				Хотод	43.2%	68%		-24.8%
				Орон нутагт	51.8%	29%	+22.8%	

ХҮРЭХ ҮР ДҮН 4: СОНГОГДСОН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН ЧАДАВХ САЙЖИРСАН БАЙХ

2019 онд хүрсэн үр дүн, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Улсын Их Хурлын хууль тогтоох болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чадавхыг дээшлүүлэхэд Төслийн хүрээнд бий болсон мэдлэгийн бүтээгдэхүүнүүд тодорхой хувь нэмэр оруулав.

Хууль тогтоогчид болон УИХ-ын Тамгын газрын ажилтнуудыг УИХ-ын хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чадавхыг сайжруулахад чиглэсэн арга зүй, мэдээлэл судалгаа, олон улсын сайн туршлагын талаарх мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангаж ажиллав.



Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээний тайлан (зөвлөмжийн хамт)-г хэвлэж, хууль тогтоогчид, эрдэмтэн судлаачдын хүртээл болгов. Мөн ХБНГУ, ОХУ, БНСУ, Автрали, Франц, Финланд, Канад зэрэг 7 улсын парламентын хуралдааны

дэг, Финланд Улсын Үндсэн хуулийг тус тус гарын авлага болгон хэвлүүлэв. Энэ мэдлэгийн багц бүтээгдэхүүн нь УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд хийсэн иж бүрэн дүн шинжилгээ, холбогдох зөвлөмж, санал болон гадаадын зарим улсын парламентын дэгийг бүрэн эхээр нь багтаасан.

Дээр дурдсан мэдлэгийн бүтээгдэхүүнийг судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах, холбогдох санал, зөвлөмжийг төрийн бодлогод тусгах, практик хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албатай хамтран 2 дугаар сарын 20-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдал, гадаад орны туршлага, түүнийг нэвтрүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт УИХ-ын дарга, гишүүд, УИХ-ын Тамгын газрын зөвлөх, холбогдох бусад албан тушаалтнууд, эрдэмтэн судлаачид, УБХ, УИХ-ын гишүүнээр ажиллаж байсан зарим хүмүүс зэрэг 80 орчим төлөөлөгчид оролцсон.



“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдал, гадаад орны туршлага, түүнийг нэвтрүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлэг
2019.02.20, Төрийн ордон

Хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн УИХ-ын зарим гишүүд УИХ-ын хараат бус, бие даасан байдлын баталгаа, түүний өдөр тутмын үйл ажиллагааны журмыг тодорхойлсон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр хуулийн төсөл санаачилж, УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслийн танилцуулгадаа дээр дурдсан тайлан, гарын авлагуудад тулгуурласан талаар дурджээ.

... Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 43 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслөөс хийсэн “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” судалгаанд суурилан, ХБНГУ, ОХУ, БНСУ, Австрали, Франц, Канад, Финланд зэрэг улсын парламентын дэгийг судалж, уг хуулийн төслийг боловсрууллаа.

“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгаас”. <http://forum.parliament.mn/projects/596>

Эндээс дүгнэхэд, төслийн хүрээнд бэлтгэн гаргасан мэдлэгийн бүтээгдэхүүнүүд нь УИХ-ын хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагааг бүтээмжтэй, үр нөлөөтэй, хариуцлагатай болгоход зохих үр нөлөө үзүүлж байна.

Төслийн хүрээнд 2019 онд бэлтгэн гаргасан мэдлэгийн бүтээгдэхүүн

№	Ном, гарын авлагын нэр	Нэр төрөл	Хуудасны тоо	Хүртээмж /хэвлэсэн тоо, зорилтот бүлэг/
НЭГ. СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН				
1	Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ /2016/, (дахин хэвлэсэн)	Судалгааны тайлан	232 нүүр	300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдийн хүртээл болгосон.
2	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ	Судалгааны тайлан	189 нүүр	1300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, бүх шатны ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, Засаг дарга, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, нутгийн өөрийн удирдлагын болон судалгаа эрдэм шинжилгээний байгууллагууд (их, дээд сургууль, ТББ, институт г.м)-ын хүртээл болгосон.
3	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” тайлан	Судалгааны тайлан	405 нүүр	300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдийн хүртээл болгосон.
4	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” зөвлөмж	Бодлогын зөвлөмж	22 нүүр	300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдийн хүртээл болгосон.
Хоёр. ГАРЫН АВЛАГА				
5	Хууль тогтоомжийн төсөл боловсруулагчийн ширээний ном: практик гарын авлага	Орчуулгын бүтээл	584 нүүр	500 хувь хэвлэж, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, хууль зүйн их, дээд сургууль, судалгааны эрдэм

				шинжилгээний байгууллага, номын сангуудын хүртээл болгосон. УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад хэрэгцээнд зориулсан.
6	Бүгд Найрамдах Финланд Улсын Үндсэн хууль	Эрх зүйн актын орчуулга	58 нүүр	300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, хууль зүйн их, дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын хүртээл болгосон.
7	Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль	Эрх зүйн актын орчуулга	104 нүүр	300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, хууль зүйн их, дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын хүртээл болгосон.
8	Австрали Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг	Эрх зүйн актын орчуулга	120 нүүр	300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, хууль зүйн их, дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын хүртээл болгосон.
9	Бүгд Найрамдах Франц Улсын Үндэсний Ассамблейн хуралдааны дэг	Эрх зүйн актын орчуулга	132 нүүр	300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, хууль зүйн их, дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын хүртээл болгосон.
10	Бүгд Найрамдах Финланд Улсын парламентын хуралдааны дэг	Эрх зүйн актын орчуулга	40 нүүр	300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, хууль зүйн их, дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын хүртээл болгосон.
11	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн хуралдааны дэг	Эрх зүйн актын орчуулга	104 нүүр	300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, хууль зүйн их, дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын хүртээл болгосон.
12	Оросын Холбооны Улсын Төрийн Думын	Эрх зүйн актын	152 нүүр	300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд,

	регламент	орчуулга		эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, хууль зүйн их, дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын хүртээл болгосон.
13	Канад Улсын парламентын акт	Эрх зүйн актын орчуулга	80 нүүр	300 хувь хэвлэж, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, хууль зүйн их, дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын хүртээл болгосон.

Улсын Их Хурлын Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж холбогдох сургалтын хөтөлбөр, гарын авлага, олон улсын сайн туршлагын бүтээгдэхүүнийг гаргаж, “Сургагч багш” нарыг бэлтгэв.

УИХ-ын Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд сургалт хөгжлийн хөтөлбөр боловруулах, түүнийг хэрэгжүүлэх багш нарын нөөцийг бүрдүүлж, чадваржуулах, холбогдох гарын авлага, олон улсын сайн туршлагын бүтээгдэхүүнээр хангах ажлыг хэрэгжүүлэв.



Төслийн хүрээнд боловсруулсан УИХ-ын Тамгын газрын төрийн албан хаагч /зөвлөх, ажилтан/-ийн сургалтын хөтөлбөрийг УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн 2019 оны 21 дүгээр захирамжаар баталсан. Хөтөлбөрийн дагуу тамгын газрын зөвлөх болон ажилтны сургалт нь i) **УИХ-ын Тамгын газрын зөвлөхийн сургалт** /зөвлөхийн суурь болон хууль тогтоомжийн төсөл боловсруулах арга зүйн сургалт/; ii) **УИХ-ын Тамгын ажилтны сургалт** /Шинэ ажилтны болон мэргэжлийн хөгжлийн дэмжих сургалт/; iii) **УИХ-ын Тамгын газрын зөвлөх, ажилтны сургалт** /Салбар дундын мэдлэг, нийгмийн мэдрэмж, чадвар хөгжүүлэх сургалт/ гэсэн үндсэн 3 төрөлтэй байна.

Энэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөцийг бэлтгэх, чадваржуулах зорилгоор “Сургагч багш бэлтгэх сургалт”-ыг /16 цаг/ 4 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулав.



Сургагч багш бэлтгэх сургалт, 2019.04.16-17, Төрийн ордон

Сургалтаар УИХ-ын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах зөвлөх, зөвлөх нийт 14 хүнийг сургагч багшаар бэлтгэж, тэдний насанд хүрэгчдийн сургалт удирдан чиглүүлэх онол, арга зүйн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэв. Мөн эдгээр сургагч багш нар 4 сарын 30-наас 5 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан “Манлайллын ур чадвар хөгжүүлэх” сургалтад хамрагдсан. /Тус сургалтын талаарх мэдээллийг “Улсын Их Хурлын Тамгын газрын удирдах албан тушаалтнууд манлайллын ур чадвараа дээшлүүлэв” хэсгээс үзнэ үү./

Сургагч багш бэлтгэх сургалтад хууль тогтоох үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн судлаач, практик ажилтнууд тодорхой сэдвээр сургалт явуулж, хууль тогтоох эрх мэдэл, хууль тогтоох байгууллагын ажилтны ажил, мэргэжлийн онцлог, баримтлах зарчим, ёс зүй болон хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл явц, хууль зүйн техникийн асуудлаарх мэдлэгийн хүрээг өргөтгөж, эдгээр сэдвээр явуулах сургалтын агуулга, хичээл удирдан явуулахад анхаарах практик зөвлөмжүүдийг өгсөн.




Сургагч багш бэлтгэх сургалт, 2019.04.16-17, Төрийн ордон

УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг зорилго хуулийн төсөл боловсруулагчдын хууль тогтоомжийн төсөл боловсруулах арга зүй, мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, холбогдох гарын авлага, сайн туршлагын бүтээгдэхүүнээр хангах явдал юм.

Энэ хүрээнд хууль тогтоомжийн төсөл боловсруулах чиглэлээр хоёр гарын авлага боловсруулж, олон улсын сайн туршлагын нэг бүтээгдэхүүнийг орчуулж, хэвлэх ажлыг гүйцэтгэв.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах арга зүйн гарын авлагыг i) Нийтийн болон хувийн эрх зүйд хамаарах салбарын хуулийн төсөл боловсруулах; ii) Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах гэсэн хоёр сэдвээр боловсруулсан. Гарын авлагын практик хэрэглээнд нийцэх байдал, холбогдох санал зөвлөмжийг авах зорилгоор Нийтийн болон хувийн эрх зүйд хамаарах салбарын хуулийн төсөл боловсруулах гарын авлагыг танилцуулах уулзалтыг УИХ-ын Тамгын газрын ахлах зөвлөх, зөвлөх, холбогдох бусад ажилтнууд нийт 40 орчим хүнийг оролцуулан 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан.



Хууль тогтоомжийн төсөл боловсруулах арга зүйн асуудлаар олон улсын сайн туршлагаар бүтээгдэхүүн гаргах зорилтын

хүрээнд Тобиас А Дорсигийн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулагчийн ширээний ном: практик гарын авлага” бүтээлийг орчуулах зөвлөх үйлчилгээг 2018 онд хэрэгжүүлсэн. Бүтээлийг хэвлэж хуулийн төсөл боловсруулагчдийн (хууль тогтоогчид, УИХ-ын Тамгын газрын зөвлөх, ажилтан г.м) хүртээл болгоход бэлэн болголоо. Уг бүтээл уншигчдын хүртээл болсоноор хууль тогтоомжийн төсөл боловсруулах арга зүй, хууль зүйн техникийн өргөн хүрээтэй, нарийн төвөгтэй асуудлуудаар шинэ мэдлэг, инноваци бий болж, улмаар Монгол Улс дахь хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны чанарыг сайжруулахад зохих хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Тухайлбал, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай зэрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулахад чухал ач холбогдолтой болов.

...төслийн хүрээнд хийгдсэн парламент дахь цөөнхийн талаар судалгаатай танилцсан УИХ-ын нэр бүхий тодорхой гишүүд Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудад цөөнхийн эрх гэдэг зохицуулалт тун бага байдаг юм байна гэсэн дүгнэлтийг хийж, холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулах гэж байна..

Төслийн 2020.02.14-ний өдрийн Удирдах зөвлөлийн хуралдаанд Төслийн үндэсний захирлын үзлэл

Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр зохион байгуулж буй сургалтууд, холбогдох сургалтын гарын авлага, мэдлэгийн бүтээгдэхүүнүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулиар хуулийн төсөл боловсруулагчдад хүлээлгэсэн шинэ үүргүүдийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулах тогтолцоог бүрдүүлэх (сургалтын хөтөлбөр, сургагч багш, гарын авлага), хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд үр нөлөө бүхий нэгдмэл практик бий болгоход зохих үр дүн өгч байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын удирдах албан тушаалтнууд манлайлын үр чадвараа дээшлүүлэв.

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.4-т заасан арга хэмжээний хүрээнд “Улсын Их Хурлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Тамгын газрын чиг үүргийг боловсронгуй болгох нь” сэдвээр удирдах ажилтнуудын сургалтыг 11 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулав.



Сургалт, семинарын үеэр УИХ-ын Тамгын газрын зохион байгуулалтын нэгжүүдийн чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтыг зөв, оновчтой тодорхойлох, Тамгын газрын дунд хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулах, удирдах ажилтнуудын манлайлал, багаар ажиллах ур чадварыг дээшлүүлэх, Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дэмжихэд парламентын гүйцэтгэх үүрэг зэрэг хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх Тамгын газрын чадавхыг

дээшлүүлэхэд чиглэсэн сэдэв, чиглэлийг хөндөж ярилцав. Сургалтад Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга, хэлтсийн дарга нар болон хүний нөөцийн ажилтнууд, гэрээт зөвлөхүүд, зарим алба нэгжийн төлөөлөл 20 хүн хамрагдав.



“УИХ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Тамгын газрын чиг үүргийг боловсронгуй болгох нь” сургалт, семинар 2019.11.09

Сургалт, семинарын үр дүнд УИХ-ын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, Стратеги төлөвлөгөө боловсруулах асуудлаар тодорхой шийдэлд хүрч, Тогтвортой хөгжлийн зорилт болон системийн сэтгэлгээ зэрэг удирдлагын түвшинд ойлголт мэдлэгтэй байж, хэрэгжилтийг манлайлж ажиллавал зохих сэдэв, чиглэлээр онол, практикийн суурь мэдлэг олгосон.

УИХ-ын Тамгын газрын зөвлөх, ажилтны сургалтын хөтөлбөрийн хүрээнд удирдах албан тушаалтнуудад зориулсан “Манлайллын ур чадвар хөгжүүлэх сургалт”-ыг 04 дүгээр сарын 30, 5 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулав.

Сургалтад УИХ-ын Тамгын газрын нэгжийн (хэлтэс, алба) дарга, ахлах референтүүд болон УИХ-ын Тамгын газрын сургалтад багшлахаар бэлтгэгдсэн Сургагч багш нар зэрэг 40 хүн хамрагдсан.



Удирдах албан тушаалтнуудад зориулсан “Манлайллын ур чадвар хөгжүүлэх сургалт” 2019.04.30-05.01, Төрийн ордон

Сургалт нь төрийн албан хаагчдад сайн манлайлагч болон удирдах албан тушаалтны манлайллын арга зүй эзэмшүүлэх, байгууллагын менежмент, стратегийн манлайлал ба төлөвлөлт, төсөл төлөвлөх, урьдаас төлөвлөн шийдвэр

гаргах онолын ойлголт олгох, манлайллын ёс зүй, багаар ажиллах арга эзэмшүүлэхэд чиглэсэн.

Сургалт I) манлайллыг тодорхойлох нь, манлайллын үнэт зүйлс, онцлог шинжүүд, II) сайн манлайлагчийн 14 шинж, удирдах албан тушаалтны манлайлал, III) багаар ажиллах ба манлайллын арга барилууд, IV) багийг манлайлан удирдах: үүргээ гүйцэтгэж буй баг, багаар ажиллах “6 С”, V) хүний нөөц ба хөгжил, VI) төслийн менежмент дэх манлайлал, VII) манлайллын ёс зүй зэрэг багц сэдвийн хүрээнд үндсэн ойлголтуудыг тайлбарлаж, практик зөвлөмжүүд өгсөн.

Парламентын эрх зүйн тодорхой сэдэв, чиглэлээр хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, парламент дахь цөөнх, УИХ-ын хяналтын чиг үүргийн талаар судалгааны бүтээгдэхүүн гаргав. Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах явцад харьцуулсан мэдээллээр хангасны үр дүнд хууль тогтоох байгууллагын Стратеги төлөвлөгөөг орчин цагийн парламентын чиг хандлагад нийцүүлэх боломжийг бүрдүүллээ.

УИХ-ын хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх Тамгын газрын үйл ажиллагааны нэг чиглэл нь судалгаа, мэдээллээр хангах явдал юм. Тайлант хугацаанд парламентын эрх зүйд холбогдох дор дурдсан гурван сэдвээр судалгааны ажил гүйцэтгүүлж, судалгааны шинжилгээний эргэлтэд оруулах бэлтгэл ажлыг хангав.

Төслийн хүрээнд гүйцэтгэсэн судалгааны ажлууд

№	Судалгааны нэр	Гол үр дүн
1	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ	УИХ-ын тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд парламентын эрх зүйн хөгжлийн онол, практик, олон улсын эх сурвалжид тулгуурлан харьцуулсан дүн шинжилгээ хийж, УИХ-ын тухай хуулийг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын зөвлөмж, саналыг боловсруулсан. Судалгааны тайланг парламентын эрх зүйг хөгжүүлэх, УИХ-ын тухай хуулийн шинэчлэлийн үзэл баримтлал, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход ашиглана.
2	Парламент дахь цөөнх /сөрөг хүчин/-ийн эрх зүйн байдал	Парламент дахь цөөнх /сөрөг хүчин/-ийн эрх үүрэг, хууль тогтоох үйл ажиллагаан дахь оролцоо, хариуцлагын асуудлаар дүн шинжилгээ хийсэн. Судалгааны тайланг УИХ дахь олонх, цөөнхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход ашиглана.
3	УИХ-ын хяналтын чиг үүрэг: эрх зүйн зохицуулалт,	УИХ-ын хяналтын чиг үүрэг, түүний хэрэгжилтийн асуудлаарх онол, практикийг нэгтгэн дүгнэж, холбогдох эрх зүйн зохицуулалт, УИХ-ын Тамгын

хэрэгжилт	газрын үйл ажиллагааг сайжруулах талаар санал зөвлөмж дэвшүүлсэн.
-----------	---

Мөн УИХ-ын Тамгын газрын судалгаа шинжилгээний чадавхыг бэхжүүлэх хүрээнд “Нийгмийн тэгш бус байдлыг бууруулах нь: мэдлэгээс төрийн бодлогод” семинарыг 7 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулав. Семинарт УИХ-ын Тамгын газар, их, дээд сургуулиуд, судалгаа шинжилгээний бусад байгууллагын төлөөлөл 80 гаруй эрдэмтэн, судлаачид оролцов.



Семинарын хүрээнд УИХ-ын хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаанд тэгш бус байдлын талаарх ойлголт мэдлэг, холбогдох судалгаа мэдээллийн санг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар хэлэлцэж, санал бодлоо солилцов.

Мөн семинарт оролцогчид нийгмийн тэгш бус байдлыг бууруулахад холбогдох байгууллагуудын судалгаа, мэдээллийн

чадавхыг дээшлүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр зөвлөмж гаргасан.

Семинарын зөвлөмжид Монгол Улсад нийгмийн тэгш бус байдлыг бууруулахын тулд шинжлэх ухааны байгууллага, шийдвэр гаргагчид хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, зохих чадавхыг бүрдүүлэх зорилгоор ЮНЕСКО-гийн “Нийгмийн өөрчлөлтийн удирдлага” хөтөлбөрт манай улс хамрагдах нь зүйтэй гэсэн санал гарч, цаашид судлан шийдвэрлэх талаар тусгасан.

Энэ асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар, Шинжлэх ухааны академиас судлан үзээд ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын зөвлөмжийг авч, “Нийгмийн өөрчлөлтийн удирдлага” хөтөлбөрийн үндэсний хороог 2019 оны 10 дугаар сард байгуулсан. Улмаар Монгол Улс ЮНЕСКО-ийн “Нийгмийн өөрчлөлтийн удирдлага хөтөлбөр”-ийн Засгийн газар хороодын зөвлөлийн Дэд ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байна.

Тус хөтөлбөр хэрэгжсэнээр Улсын Их Хурлаас батлан гаргах хууль тогтоомжийг шинжлэх ухааны үндэслэл бүхий нотолгоонд суурилсан судалгаа, лавлагаа, мэдээллээр хангахад шинжлэх ухааны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн өмнө тулгамдаж байгаа олон асуудлыг судлан шийдвэрлэх чиглэлээр ард түмэнд өгөөжөө өгсөн шийдвэр гарган хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл.



Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах хүрээнд төрийн бодлого, стратеги төлөвлөлтийн чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтран ажиллаж УИХ-ын стратеги төлөвлөгөө /2019-2024 он/-ний төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллав. Энэ зорилгоор Олон улсын Парламентын холбооны стратеги төлөвлөгөө, зөвлөмж, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс, Намиби Улс, Соломоны арлууд, Шотланд Улсын парламентын стратеги төлөвлөгөөг орчуулж, эмхэтгэл болгосон. Үүний үр дүнд хууль тогтоогчид, Тамгын газрын ажилтнуудыг парламентын стратеги төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай харьцуулсан судалгаа, мэдээллээр хангасан бөгөөд УИХ-аас 12 дугаар

сарын 21-ний өдөр УИХ-ын Стратеги төлөвлөгөөг шинэчлэн баталж, орчин цагийн парламентын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэв.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагаа тогтвортой үргэлжилж, хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх чадавх, туршлага нэмэгдэв. Хамтын ажиллагааны үр дүн, хуримтлуулсан туршлагад тулгуурлан УИХ-ын Тамгын газарт Хяналт шалгалт, үнэлгээний бие даасан нэгжийг шинэчлэн байгуулж, хүний нөөцийг нэмэгдүүлэв. Түүнчлэн хууль тогтоомжийн хэрэгжилт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, журмын төслийг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.

Төслийн хүлээгдэж буй үр дүнгийн нэг чухал хэсэг нь хууль тогтоомжийн тухай хуулиар бий болсон зарим шинэ чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх арга зүй, хүний нөөцийн чадавхыг сайжруулах юм.

Энэ хүрээнд УИХ-ын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагаа 2017 оноос хойш тогтвортой үргэлжилж байна. Энэ хүрээнд дараах ажлууд хийгдэв:

- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, тайлан боловсруулах ажлыг Швейцарын парламентын Тамгын газрын арга зүйн зөвлөгөө, дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжүүлэв. Хуулийн хэрэгжилтэд хийх үнэлгээний арга зүйг нарийвчлан боловсруулж, мэдээлэл цуглуулах ажлыг 3 аймаг, 5 дүүрэгт зохион байгуулав.
- Хоёр улсын парламентын Тамгын газар хоорондын 4 дэх семинарыг 4 дүгээр сарын 29-нөөс 5 дугаар сарын 03-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Семинарын хүрээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтэд хийж буй үнэлгээний аргачлалыг сайжруулах, тайланг үр дүнтэй боловсруулах чиглэлээр ажилласан бөгөөд УИХ-ын Тамгын газрын холбогдох ажилтнууд хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх арга зүй боловсруулах (асуулт боловсруулах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх), тайлан боловсруулах практик ур чадвар, туршлагаа нэмэгдүүлэв.



УИХ-ын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар хоорондын IV дэх семинар, Төрийн ордон, НҮБ-ын Төв байр, 2019.04.29-05.03

- УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчид 12 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд Швейцар улсад ажиллаж, хоёр орны хамтран

хэрэгжүүлсэн хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний үр дүнг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцов. Швейцарын парламентын Тамгын газрын зүгээс Монгол Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын төсөл болон үнэлгээний ажилтны гүйцэтгэх ажил үүргийн тодорхойлолтод санал хүргүүлэх, цаашид үнэлгээ хийх ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр хамтран ажиллах саналаа илэрхийлэв. Түүнчлэн хуулийн төсөлд иргэний нийгмийн саналыг авах ажиллагаа, парламентын хяналтын чиг үүргийг бэхжүүлэх чиглэлээр хамтарсан сургалт, семинар зохион байгуулах талаар тохиролцлоо.

Шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн танилцуулга бэлтгэн иргэдэд, тэр дундаа харааны бэрхшээлтэй болон үндэсний цөөнх иргэдийн онцлогт зориулан боловсруулав.

Улсын Их Хурлаас 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг баталсан. Энэхүү өөрчлөлт нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл болон нутгийн удирдлагын талаарх эрх зүйн шинэчлэлийн эх сурвалж болох бөгөөд тэдгээр суурь шинжтэй өөрчлөлтийг хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх иргэдийн онцлогт нийцсэн хэлбэрээр хүргэхэд анхаарч ажиллалаа.



Энэ хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаарх зурагт танилцуулгыг **Монгол-Казак** хэлээр, мөн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн энгийн хувилбарыг **Брайл үсгээр** хэвлэхэд бэлэн болгов. Ингэснээр 94 мянга орчим үндэсний цөөнх /казак/ иргэд төрөлх хэлээрээ, 10 мянга гаруй харааны бэрхшээлтэй иргэд өөрсдийн хэрэглэдэг Брайл үсгийн тусламжтайгаар Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй танилцах боломж бүрдэж байна. Энэ нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, хууль тогтоомжийн талаарх мэдээллийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх шинэ практик тогтоож буй юм.

Сорилт бэрхшээл, амжилтын хүчин зүйлс ба сургамж

- Төслийн хүрээнд гүйцэтгэсэн “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” болон Бүгд Найрамдах Финланд Улсын Үндсэн хууль, зарим улс орнуудын /Австрали, БНСУ, ОХУ, ХБНГУ, Франц, Финланд, Канад улс/ парламентын хуралдааны дэгийн гарын авлага нь хууль тогтоогчид болон УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, судлаачдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, цаг үеэ олсон болох нь хуулийн төсөл болон холбогдох тайлбар, санал дүгнэлт боловсруулахдаа тэдгээрт үндэслэсэн, эшилсэн байдлаас харагдаж байна. Энэ нь эдгээр мэдлэгийн бүтээгдэхүүнүүд шууд болон шууд бус байдлаар хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагааг сайжруулахад зохих нөлөө үзүүлж байгааг илэрхийлэх үзүүлэлт юм.
- Нийтийн сонсголын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр төслийн хүрээнд 2018 оны эцэст арга зүйн сургалт зохион байгуулж, БНСУ-ын Үндэсний Ассамблейн туршлагыг судлах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Энэ арга хэмжээнд хамрагдсан УИХ-ын гишүүд болон УИХ-ын Тамгын газрын холбогдох албан тушаалтнуудын манлайлал, идэвхтэй оролцоотойгоор 2019 онд УИХ-аас нийт 7 удаагийн сонсгол зохион байгуулсан. Нийтийн сонсголын тухай хууль 2015 онд батлагдсан ч 2017 онд /Б.Хурцыг БНСУ-д суух Элчин сайдаар томилох асуудалтай холбогдуулан/ хийсэн сонсголоос өөр уг хуулийн дагуу сонсгол зохион байгуулсан практик байгаагүй юм. 2019 онд 7 нийтийн сонсгол зохион байгуулагдсан нь УИХ-ын Тамгын газрын холбогдох албан тушаалтнууд Нийтийн сонсголын тухай хууль, холбогдох журмыг хэрэглэх аргачлал болон сонсгол зохион байгуулах практик ур чадвараа дээшлүүлсэнтэй холбоотой юм.
- УИХ-ын Тамгын газрын ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг явуулах Сургагч багш нарыг бэлтгэсэн нь шинэ үйл ажиллагаа боллоо. Энэ нь төслийн хүрээнд бэлтгэн гаргасан мэдлэгийн бүтээгдэхүүнийг (ном, гарын авлага, тайлан г.м) сургалт, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах замаар практик хэрэглээг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах гол механизм болох ач холбогдолтой.
- УИХ-ын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагаа тогтвортой үргэлжилж байгаа нь УИХ-аас хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй болон хүний нөөцийн чадавх сайжирч, практик туршлага нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлсээр байна. Хоёр улсын парламентын тамгын газрууд хууль тогтоох, хяналтын чиг үүргийг бэхжүүлэх чиглэлээр цаашид хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхээр болсон тул төслийн хүрээнд эдгээр үйл ажиллагааг тусгаж, хөрөнгө нөөц хуваарилан ажиллах шаардлагатай болж байна.

Цаашид хийх ажил, тогтвортой байдал

- Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай зэрэг хуулиудыг нийцүүлэх замаар хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих УИХ-ын бүрэн

эрх, чиг үүргийг боловсронгуй болгоход судалгаа дүн шинжилгээ, мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр дэмжлэг үзүүлнэ.

- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал, практик ур чадварыг хөгжүүлэх зорилгоор мэдлэгийн бүтээгдэхүүн гаргах, холбогдох албан тушаалтнуудыг сургаж дадлагажуулах арга хэмжээг олон улсын болон дотоодын зөвлөх мэргэжилтнүүд, төслийн хүрээнд бэлтгэсэн “Сургагч багш нар”-ын оролцоотойгоор үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.
- УИХ-ын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааг шинэ агуулгаар баяжуулж, хууль тогтоомжийн төсөлд санал авах ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага, иргэдийг оролцуулах, уг үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх, парламентын хяналтыг бэхжүүлэхэд Швейцарын парламентын сайн туршлага, аргачлалыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Төслийн үр дүнгийн хүснэгт /Хүрэх Үр дүн 2-ын хүрээнд/

Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт/он		Зорилт	2019 онд хүрсэн түвшин	2017-2019	Мэдээлэл, нотолгооны эх сурвалж
4.1. УИХ-ын Тамгын газар, орон нутгийн ИТХ-аас хэрэгжилтэд нь мониторинг хийсэн хуулийн тоо		2016	1 он1; 1 он2; 1 он3; 1 он4;	1 (Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль); Үнэлгээний арга зүйг боловсруулж буй;	Хэрэгжиж буй. 2 (Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль); (Газар өмчлүүлэх тухай хууль)	УИХ-ын Тамгын газар
4.2. УИХ, ИТХ-аас зохион байгуулсан нийтийн сонсголын тоо	0	2016	10 он1; 10 он2; 15 он3; 15 он4	УИХ-аас 6 нийтийн сонсгол;	Биелэгдсэн. УИХ- нийтийн сонсгол 6 удаа ИТХ 2019 онд -нийтийн сонсгол 421 удаа: 79-аймгийн ИТХ 342-сумын ИТХ	www.parliament.mn 2020 оны 3 сард ИТХ-аас цуглуулсан мэдээлэл
4.3. Төслийн дэмжлэгээр хийсэн судалгаа, дүн шинжилгээний тоо	-	2016	2 он1; 2 он2; 2 он3; 2 он4;	2 судалгаа: (ЗЗНДНТУтХуулийн хэрэгжилт); (УИХ-ын чуулганы хуралдааны дэг);	Хэрэгжиж буй. 4 судалгаа: (парламент дахь сөрөг хүчний эрх зүйн байдал); (парламентын хяналтын чиг үүрэг);	УИХ-ын Тамгын газар;

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- УИХ-ын Тамгын газар нь төслийн үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болохын хувьд төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, бодлого, агуулгын талаас чиглүүлэн ажиллаж байгаа нь төслийг амжилттай хэрэгжүүлэх чухал хүчин зүйл болж байна. Тухайлбал, тэтгэлэгт хөтөлбөрийн саналыг сонгон шалгаруулах ажлын хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу байгуулагдах үнэлгээний хороо, зөвлөх болон бусад үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох хэлтэс, нэгжийн ажилтнууд томилогдон ажиллаж байна. Түүнчлэн эхний хагас жилд зохион байгуулагдсан үндэсний

хоёр том чуулган зохион байгуулахад Тамгын газрын ажилтнууд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажиллав.

- Швейцарын хөгжлийн агентлагийн хамтын ажиллагааны хүрээнд нутгийн удирдлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг LOGIN олон улсын сүлжээ байгууллагатай харилцаа тогтоов. Тус байгууллагын “Харилцан суралцах арга зүй” сургалтад “МонФемнет” ТББ, аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нар хамрагдсан.
- ЗГХЭГ-ын Мэдээллийн технологийн хэлтэс www.khural.mn цахим хуудасны техникийн асуудлыг хариуцан ажиллаж, аймаг, дүүргийн админуудад мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлж байна. Түүнчлэн үндэсний чуулган, бүсийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, тэдгээрийн үеэр мэдээлэл, танилцуулга хийх, орон нутгийн зүгээс илэрхийлсэн хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой саналтай танилцах, хариу тайлбар өгөх зэргээр хамтран ажиллаж байна.
- Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын Ажлын албадтай байнгын холбоотой ажиллаж байна. Нарийн бичгийн дарга нар тодорхой чиглэлүүдэд байгуулагдсан ажлын хэсгүүдэд орж ажиллахын зэрэгцээ ИТХ-ын талаар судалгаа мэдээлэл цуглуулахад чухал дэмжлэг үзүүлж байна.

ЖЕНДЕР, ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛУУД

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төлөөлөгч эмэгтэйчүүд, УИХ, Засгийн газар, төрийн байгууллага, олон улсын байгууллагын 400 гаруй эмэгтэй улс төрчид харилцан туршлага солилцож, дуу хоолойгоо нэгтгэн, сайн туршлагаа хуваалцав.
- Эмэгтэй төлөөлөгчдийн санаачлан хийж хэрэгжүүлсэн ажлууд сайн туршлагын эмхэтгэл болон хэвлэгдэв.
- Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр төслүүд хэрэгжлээ.
- “Төлөөлөгчийн манлайлал” сургалтын үр дүнд хүний эрхийг хамгаалах санаачилга Дундговь аймагт хэрэгжиж, ТББ-ууд болон олон нийтэд энэ талаар мэдээллээ.

ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ

- Төслийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төслийн удирдах зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн V хуралдаанаар баталсан.
- Төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн зохицуулагч, санхүүгийн ажилтан, хяналт үнэлгээний ажилтан болон жолооч гэсэн үндсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Мэдлэгийн менежментийн чиглэлээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байсан НҮБ-ын сайн дурын ажилтаны гэрээний хугацаа 3 дугаар сарын 31-нд дуусгавар болж, сонгон шалгарсан дараагийн сайн дурын ажилтан 8 дугаар сараас эхлэн ажиллаж байна. Төслийн Хүрэх үр дүн 4-ийн хүрээнд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч нь Төсөл хэрэгжүүлэх нэгжид бүтэн цагаар ажиллаж байна.
- УИХ-ын Тамгын газар нь Төслийн үндэсний хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд төслийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд УИХ-ын Тамгын газар хариуцахаар тусгагдсан үйл ажиллагаанууд, тухайлбал худалдан авалтад дотоодын хуулийн зохицуулалтыг баримтлан ажиллаж байна. Энэ хүрээнд

худалдан авалттай холбоотой Үнэлгээний хороонд Тамгын газрын ажилтнууд томилогдон ажиллаж байна.

- 2019 онд гэрээт ажлын гүйцэтгэлийг хүлээн авах үүрэг бүхий 9 ажлын хэсэг, тендерийн хуулийн дагуу худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх 7 үнэлгээний хороо УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар байгуулагдсан байна. Эдгээр бүх ажлын хэсэг, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төслийн ажилтнууд орж, бичиг баримт боловсруулах, хурал зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх үүрэгтэй нарийн бичгийн даргаар ажиллалаа.
- Шилэн дансны цахим хуудаст төслийн үйл ажиллагатай холбоотой 24 төрлийн мэдээллийг тухай бүр нийтэлж байна.

ХАВСРАЛТ

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран хийсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зарим гол үр дүнгийн талаар судалгаа, 2019 оны 3 сар
- Аймаг, сумдын ИТХ-аас авсан судалгаа, 2020 оны 3 сар